



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН
ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР

Төрийн ордон, Жанжин Д.Сүхбаатарын талбай,
6 дугаар хороо, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14201
Утас: (976-51) 26 08 17, Факс: (976-51) 26 24 08,
Цахим шуудан: info@cabinet.gov.mn,
Цахим хуудас: www.cabinet.gov.mn

2025.05.05 № ХХ/1268
танай _____-ны № _____-т

Асуултын хариу хүргүүлэх тухай

Танаас Ашигт малтмалын тухай хуулийн хэрэгжилт болон "Оюу толгой" ордтой холбоотой асуудлаар Монгол Улсын Ерөнхий сайдад тавьсан асуултын хариуг Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамнаас бэлтгэн ирүүлснийг хүргүүлж байна.

Хүлээн авч, танилцана уу.

Хавсралт 37 хуудастай.

МОНГОЛ УЛСЫН САЙД,
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ
ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА



Н.УЧРАЛ

000255008444



**МОНГОЛ УЛСЫН АЖ ҮЙЛДВЭР,
ЭРДЭС БАЯЛГИЙН САЙД**


15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Нэгдсэн үндэстний гудамж 5/1, Засгийн газрын II байр,
Утас: (976-51) 26-35-06,
Цахим шуудан: info@mimr.gov.mn
цахим хуудас: www.mimr.gov.mn

2025.05.01 № 01/1346
танай 2025.04.17 -ны № dm/1016 -т

「МОНГОЛ УЛСЫН САЙД, ЗАСГИЙН
ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗРЫН
ДАРГА Н.УЧРАЛ ТАНАА」

Монгол Улсын Их Хурлын гишүүн
О.Батнайрамдалаас Монгол Улсын Ерөнхий
сайдад тавьсан Оюу толгой ордтой холбоотой
Асуултын хариу мэдээллийг хавсралтаар хүргүүлж
байна.

Хавсралт



1508 08 0639



ЭРДЭНЭС ОЮУ ТОЛГОЙ ХХК

16 тоот, 14 давхар, Мөнхсүх цамхаг,
Чингисийн өргөн чөлөө 15, 1 дүгээр хороо,
Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14240
Утас/Факс: (976) 7007 8085 Цахим хуудас www.eot.mn

2025.04.29 № 01/104
танай 2025.04.22 -ны № 02/1220 -г

АЖ ҮЙЛДВЭР, ЭРДЭС БАЯЛГИЙН
ЯАМНЫ ТӨРИЙН НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА
С.ЖАВХЛАНБААТАР ТАНАА

Мэдээлэл хүргүүлэх тухай

Танаас ирүүлсэн 2025 оны 4 дүгээр сарын 22-ны өдрийн 02/1220 дугаартай албан бичиг, түүнд хавсаргасан Улсын Их Хурлын гишүүн О.Батнайрамдалын "Асуулт тавих тухай" 2025 оны 4 дүгээр сарын 10-ны өдрийн 17 дугаартай албан бичгээр Монгол Улсын Ерөнхий сайдад тавьсан 10 асуултыг хүлээн авч, танилцлаа.


Улсын Их Хурлын гишүүн О.Батнайрамдалаас Монгол Улсын Ерөнхий сайдад тавьсан "Асуулт"-д холбогдох мэдээллийг хавсралтаар Танд хүргүүлж байна.

Улсын Их Хурлын гишүүн О.Батнайрамдалаас ирүүлсэн "Асуулт"-уудаас 4 асуулт нь хуулиар хүлээсэн чиг үүрэг, эрхлэх асуудлын хүрээнд Монголбанк, Татварын ерөнхий газар болон "Оюу Толгой" ХХК-д хамаарч байх тул асуулттай холбогдуулан тэдгээрээс мэдээлэл хүсэж, албан бичгээр хандан нэмэлт мэдээллийг ирүүлмэгц Танд яаралтай эргэн хүргүүлье.

Хавсралт: 35 хуудастай.

Хувийг: "Эрдэнэс Монгол" ХХК-ийн Гүйцэтгэх захирал Н.Наранцогт Танаа.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН
ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ

 Э.ГАНХҮҮ

ЭРДЭНЭС МОНГОЛ НЭГДСЛИЙН ГИШҮҮН

0000000233

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН О.БАТНАЙРАМДАЛААС
МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙДАД ТАВЬСАН
АСУУЛТАД ХОЛБОГДОХ МЭДЭЭЛЭЛ**

Асуулт 1.

"Улсын Их Хурлын 2007 оны 27 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордод хамааруулсан Оюу Толгойн зэс, молибденийн бүлэг ордтой холбогдох таван ашиглалтын тусгай зөвшөөрлийн хоёр тусгай зөвшөөрөл (MV-015225, MV-015226)-ийг Онтрэ ХХК эзэмшдэг бөгөөд уг тусгай зөвшөөрлүүдийн талбайд бүлэг ордын нийт батлагдсан нөөцийн 30 орчим хувь ноогдож байна. Тус тусгай зөвшөөрлүүдтэй холбогдох асуудлаар 2024 оны 12 дугаар сарын 19-ний өдөр гаргасан Канад улсын Ванкувер хотын арбитрын шүүхийн шийдвэрийг харгалзан Монгол Улсын Үндсэн хуулийн зургаадугаар зүйлийн 6.2, Ашигт малтмалын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3, 5.5 дахь хэсэгт тус тус заасны дагуу төрийн эзэмшлийн хувь хэмжээг хэрхэн тогтоох, Монгол Улсын эрх ашгийг хангуулах асуудлыг хэрхэн шийдвэрлэх яриа хэлэлцээ эхэлсэн эсэх болон явцын талаарх мэдээлэл;"

ЭОТ ХХК-ийн хариулт:

Нэг. Антре гоулд (одоогийн нэр Антре ресурс лимитэд)-ын талаар

Оюу толгой (ОТ) төслийн "Хөрөнгө оруулалтын гэрээ" (ХӨОГ)-ний 15.7.8-д "Антре гоулд компанийн эзэмшиж буй 3148Х, 3150Х тоот хайгуулын тусгай зөвшөөрөл ..." гэж Антре гоулд компанийн тухай дурдагдсан. Тус компанийн талаар товч мэдээлэл өгөхөд,

- 1995.07.19 – Анх "Timpete Mining Corporation" нэртэйгээр Канадын Бритиш Колумбия-д байгуулагдсан;
- 2001.02.05 – "Entrée Resources Inc" (Антре ресурс)- болгож нэрээ өөрчилсөн;
- 2002.10.09 – "Entrée Gold Inc" (Антре гоулд) болгож нэрээ өөрчилсөн;
- 2005.11.18 – Антре гоулд компани нь өөрийн охин компани болох гадаадын хөрөнгө оруулалттай "Онтрэ" ХХК-г Монгол Улсын хуулийн дагуу үүсгэн байгуулж, хуулийн этгээдийн улсын бүртгэлд бүртгэгдсэн;
- 2009.10.06 - ОТ ХӨОГ байгуулагдах үед "Entrée Gold Inc" буюу "Антре гоулд компани" гэж тус гэрээний 15.7.8-д дурдагдсан;
- ХӨОГ-ний 15.7.8-д дурдагдсан 3148Х, 3150Х тоот хайгуулын тусгай зөвшөөрлүүд (одоо MV-015225, MV-015226 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөл болсон)-ийг Антре гоулд компанийн охин компани болох Монгол Улсад бүртгэлтэй "Онтрэ" ХХК эзэмшдэг;
- 2017.05.12 – "Entrée Gold Inc" (Антре гоулд) нь хуулийн этгээдийн өөрчлөлтөөр "Entrée Resource" ltd (Антре ресурс лимитэд - АРЛ) болон "Mason resource corp" (Мэйсон ресурс) болж хуваагдсан;
- Монгол Улсын хуулийн этгээдийн улсын бүртгэлд "Онтрэ" ХХК-ийн эцсийн өмчлөгч нь "Entrée Resource" ltd (Антре ресурс лимитэд - АРЛ) гэж бүртгэгдсэн;
- "Онтрэ" ХХК-ийн эзэмшиж буй ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрлүүд (Жавхлант MV-015225, Шивээ толгой MV-015226)-ийг гэрээний

үндсэн дээр ОТ ХХК-д шилжүүлэх хэлэлцээрт "Онтрэ" ХХК-ийн толгой компани болох Антре ресурс лимитэд (АРЛ) компани нэг тал болж оролцсон.

Хоёр. "Онтрэ" ХХК-ийн ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрлийн талаар

"Онтрэ" ХХК-ийн эзэмшиж буй Өмнөговь аймгийн Ханбогд сумын нутагт орших "Жавхлант" MV-015225 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөл, "Шивээ толгой" MV-015226 тоот ашиглалтын тусгай зөвшөөрлийн талаарх товч мэдээллийг дор үзүүлэв.

Тусгай зөвшөөрлийн нэр	MV-015225	MV-015226
Тусгай зөвшөөрлийн огноо	2009-10-27	2009-10-27
Хугацаа	2039-10-27	2039-10-27
Тусгай зөвшөөрлийн газрын нэр	Өмнөговь аймгийн Баян-Овоо, Ханбогд сум	Өмнөговь аймгийн Баян-Овоо, Ханбогд сум
Тусгай зөвшөөрлийн газрын нэр	Жавхлант	Шивээ толгой
Тусгай зөвшөөрлийн газрын талбай	20327.4 гектар	42592.58 гектар
Тусгай зөвшөөрлийн газрын төрөл	Үгүй	Үгүй
Тусгай зөвшөөрлийн газрын зориулалт	Үгүй	Кадастрын хэлтсийн даргын 2015 оны 866 дугаар шийдвэрээр анх олгосон 54,652.58 га талбайгаас 12,059.99 га талбайг буцаан өгснийг бүртгэснээр 42,592.58 га талбай үлдсэн.
Тусгай зөвшөөрлийн газрын хэрэгцээ	Төмөр замын зурвас газартай 528.02 га; Усан сан бүхий талбайтай 12.50 га; Засгийн газрын 2011 оны 175 дугаар тогтоолоор Улсын тусгай хэрэгцээнд авсан газар /SSA-01171/-тай 9060.28 га талбайгаар тус тус давхцалтай.	Усан сан бүхий талбайтай 57.06 га; Засгийн газрын 2010 оны 140 дугаар тогтоолоор тусгай хэрэгцээнд авсан газар /SSA-01121/-тай 1157.07 га; ЗГ-ын 2011 оны 175 дугаар тогтоолоор Улсын тусгай хэрэгцээнд авсан газар /SSA-01170, SSA-01171, SSA-01172/-тай 13726.5 га талбайгаар тус тус давхцалтай.

Зураг. "Онтрэ" ХХК-ийн эзэмшиж буй Ашигт малтмал тусгай зөвшөөрлийн талбайг харуулсан байдал

Гурав. Туркойз Хилл ресурс ба Антре гоулд компаниудын хэлцлийн талаар

Оюу Толгой төслийн "Хөрөнгө оруулалтын гэрээ" байгуулагдахаас өмнө "Туркойз хилл ресурс" (буюу ТРК гэж товчлох) компани, нөгөө талаас "Антре гоулд" (одоогийн нэр "Антре ресурс лимитэд" буюу АРЛ гэж товчлох) компаниуд 2004 онд "Ашиг хуваах гэрээ"-г байгуулсан. Гэрээний гол зохицуулалт, агуулга нь Антрегийн талбай дахь геологийн судалгаа, хайгуулын ажлын зардалд ТРК нь 35 сая ам.доллар, түүнээс дээш хэмжээний хөрөнгө оруулалт хийсэн тохиолдолд, түүнчлэн олборлолт хийх гүн нь газрын гадаргаас доош 560м хүртэл бол 70% (ТРК) болон 30% (АРЛ), хэрэв 560м доош бол 80% (ТРК) болон 20% (АРЛ) хувийн эдийн засгийн өгөөж хүртэхээр тохиролцсон. Талууд "Ашиг хуваах гэрээ"-г хэрэгжүүлэх зорилгоор "Хамтран ажиллах гэрээ"-ний төслийг хэлэлцэн тохиролцож, мөн ондоо буюу 2004 онд "Ашиг хуваах гэрээ"-нд нэмэлт, өөрчлөлт оруулж, түүний хавсралтаар "Хамтран ажиллах гэрээ"-г байгуулахаар тохиролцсон. Тухайн үед "Ашиг хуваах гэрээ"-нд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай гэрээнд хавсаргагдсан "Хамтран ажиллах гэрээ"-ний төсөл нь ирээдүйд байгуулагдахаар төлөвлөгджээ. Улмаар ТРК нь дээрх эрх (Антрегийн талбайгаас 70% хувь эсхүл 80% хувийн ашиг хүртэх)-ээ 2005 онд "Эрх шилжүүлэх гэрээ"-ний үндсэн дээр "Айвенхоу Майнз Монголия Инк" (одоогийн нэр нь "Оюу Толгой" буюу ОТ гэж товчлох) ХХК-д шилжүүлсэн.

Дөрөв. "Оюу Толгой" ХХК ба Антре гоулд компанийн ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй талбай дахь нөөц, эдийн засгийн үзүүлэлтийн талаар

Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөл (ЭБМЗ) нь 2007 оноос 2024 оныг дуустал хугацаанд Өмнөговь аймгийн Ханбогд сумын нутагт орших Оюутолгойн зэс-алтны бүлэг ордын нөөцийг хүлээн авахтай холбоотой асуудлаар 3 удаа, ТЭЗҮ-наг хүлээн авахтай холбоотой асуудлаар 3 удаа тус тус хуралдан холбогдох дүгнэлтүүдийг гаргаж байсан бөгөөд эдгээр дүгнэлтэд "Онтрэ" ХХК болон MV-015225, MV-015226 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй холбоотой тодорхой асуудлууд дурдагдсан байна. Үүнд:

1) ЭБМЗ-ийн 2009 оны 7 дугаар сарын 01-ний өдрийн "Оюу толгойн зэс-алтны орд газарт 2000-2008 онуудад хийсэн хайгуулын ажлын үр дүнгийн тайланг хэлэлцсэн тухай" 15-01 дугаартай дүгнэлтийн 1 дэх хэсэгт: "... Онтрэ ХХК-ийн 2003 онд олгогдсон 3148Х дугаартай хайгуулын тусгай зөвшөөрөлтэй талбайд оршдог Хойд Хюго ордын хойд үргэлжлэл дээр бодитой В ба боломжтой С-гээр ба 3150Х дугаартай хайгуулын тусгай зөвшөөрөлтэй талбайд оршдог Херуга ордод боломжтой С-гээр Геологийн нөөцийг хамтран хайгуул хийж тогтоосон байна. Айвенхоу Майнз Монголия Инк ХХК хайгуулын ажилд нийт 171.1 тэрбум төгрөг зарцуулснаас хамтран хайгуул хийсэн Онтрэ ХХК-ийн 3148Х дугаартай талбайд 22.5 тэрбум төг, 3150Х дугаартай хайгуулын тусгай зөвшөөрөлтэй талбайд 24.9 тэрбум төг-ийг тус тус зарцуулсан байна." гэж, мөн дүгнэлтийн Ашигт малтмалын газрын даргад уламжлахаар шийдвэрлэсэн хэсгийн 11 дэх хэсэгт: "ОНТРЭ" ХХК-ийн эзэмшиж буй 3148Х, 3150Х тусгай зөвшөөрөлтэй талбайд явуулах геологи, уул уурхайн үйл ажиллагааны асуудлыг нэг мөр болгон шийдвэрлэхийг "Айвенхоу майнз монголия инк" ХХК-д үүрэг болгох" гэж тус тус дурдсан байна.

2) ЭБМЗ-ийн 2010 оны 3 дугаар сарын 25-ны өдрийн "Оюу толгойн бүлэг ордыг ашиглах уурхай баяжуулах үйлдвэрийн ТЭЗҮ-г хэлэлцсэн тухай" 24-01 дугаартай дүгнэлтийн 2 дах хэсэгт: "...Монгол Улсын Засгийн газартай байгуулсан Хөрөнгө оруулалтын гэрээний дагуу 2009 оны 12 дугаар сард АММИ ХХК нь "Оюу толгой" ХХК болон өөрчлөн байгуулагдсан бөгөөд Оюу толгой төслийн хэрэгжүүлэгч юм. АММИ ХХК нь Оюу толгойн 6708А, 6709А, 6710А ашиглалтын тусгай зөвшөөрлүүд болон "Онтрэ" ХХК-тай хамтран эзэмших гэрээний үндсэн дээр 3148Х хайгуулын тусгай

зөвшөөрлөөр олгогдсон Шивээ толгойн, 3150Х хайгуулын тусгай зөвшөөрлөөр олгогдсон Жавхлантын талбайд үйл ажиллагаа явуулж байна." гэж дурдсан байна.

3) ЭБМЗ-ийн 2014 оны 10 дугаар сарын 11-ний өдрийн "Өмнөговь аймгийн Ханбогд сумын нутагт орших Оюу Толгойн зэс-алтны бүлэг ордын Оюут (MV- 006709), Хюго Дамметт (MV-006709, MV-015226), Херуга (MV-006709, MV- 015225) ордуудад 2009-2014 онуудад гүйцэтгэсэн хайгуулын ажлын нөөцийн тодотгол тооцооны тайланг хэлэлцсэн тухай" СТР-/14 дугаартай дүгнэлтийн 1 дэх хэсэгт: "... Жавхлант нэртэй MV-015225 тоот тусгай зөвшөөрлийн талбайд хамрагдах Херуга ордын Херуга хэсгийн эдийн засгийн үр ашигтай боломжтой (С) зэргийн нөөцийг 562.284 мян.тн хүдэрт 0.46%-ийн дундаж агуулгатай зэс (зэсийн дүйцүүлсэн агуулгыг дунджаар 0.78%)-ийг 2.598 мян.тн-оор, 0.48 гр/тн-ын дундаж агуулгатай алтыг 269 тн-оор, 1.67 гр/тн-ын дундаж агуулгатай мөнгийг 941 тн-оор, 137 гр/тн-ын дундаж агуулгатай молибденийг 77 мян.тн-оор, тодорхой нөхцөлд эдийн засгийн үр ашигтай боломжтой (С) зэргийн нөөцийг 1.137.355 мян.тн хүдэрт 0.35%-ийн дундаж агуулгатай зэс (зэсийн дүйцүүлсэн агуулгыг дунджаар 0.57%)-ийг 4.026 мян.тн-оор, 0.32 гр/тн-ын дундаж агуулгатай алтыг 366 тн-оор, 1.25 гр/тн-ын дундаж агуулгатай мөнгийг 1.421 тн-оор, 102 гр/тн-ын дундаж агуулгатай 115 мян.тн-оор, Шивээ толгой нэртэй MV-015226 тоот тусгай зөвшөөрлийн талбайд хамрагдах Хойд Хюгогийн үргэлжлэл хэсгийн эдийн засгийн үр ашигтай бодитой болон боломжтой (В+С) зэргийн нөөцийг 193.980 мян.тн хүдэрт 1.55%-ийн дундаж агуулгатай зэс (зэсийн дүйцүүлсэн агуулгыг дунджаар 1.90%)-ийг 3.011 мян.тн-оор, 0.55 гр/тн-ын дундаж агуулгатай алтыг 107 тн-оор, 4.03 гр/тн-ын дундаж агуулгатай мөнгийг 782 тн-оор, тодорхой нөхцөлд эдийн засгийн үр ашигтай бодитой болон боломжтой (В+С) зэргийн нөөцийг 101.551 мян.тн хүдэрт 0.75%-ийн дундаж агуулгатай зэс (зэсийн дүйцүүлсэн агуулгыг дунджаар 0.90%)-ийг 765 мян.тн- оор, 0.23 гр/тн-ын дундаж агуулгатай алтыг 23 тн-оор, 2.03 гр/тн-ын дундаж агуулгатай мөнгийг 207 тн-оор зохиогчдын тооцоолсон хувилбараар, хүснэгт 1-1, 1-2, 1-3-ын дагуу тус тус хүлээн авах." гэж дурдсан байна.

4) ЭБМЗ-ийн 2015 оны 6 дугаар сарын 12-ны өдрийн "Өмнөговь аймгийн Ханбогд сумын нутагт орших MV-006709 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй Оюу толгой, MV-015225 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй Жавхлант, MV- 015226 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй Шивээ толгой нэртэй Оюу толгойн зэс-алтны бүлэг (Оюут, Хюго Дамметт, Херуга) ордыг ашиглах техник- эдийн засгийн үндэслэл (тодотгол)-ийг хэлэлцсэн тухай" Стр-05/15 дугаартай дүгнэлтийн 3 дах хэсэгт: "... Жавхлант нэртэй MV-015225 тоот тусгай зөвшөөрлийн талбайд хамрагдах Херуга ордын Херуга хэсгийн эдийн засгийн үр ашигтай боломжтой (С) зэргийн нөөцийг 562.284 мян.тн хүдэрт 0.46%-ийн дундаж агуулгатай 2.598 мян.тн зэс, 0.48 гр/тн-ын дундаж агуулгатай 269 тн алт, 1.67 гр/тн-ын дундаж агуулгатай 941 тн мөнгө, 137 гр/тн-ын дундаж агуулгатай 77 мян.тн молибден, (зэсийн дүйцүүлсэн агуулгыг дунджаар 0.78%) тооцож тодорхой нөхцөлд эдийн засгийн үр ашигтай боломжтой (С) зэргийн нөөцийг 1.137.355 мян.тн хүдэрт 0.35%-ийн дундаж агуулгатай 4.026 мян.тн зэс, 0.32 гр/тн-ын дундаж агуулгатай 366 тн алт, 1.25 гр/тн-ын дундаж агуулгатай 1.421 тн мөнгө, 102гр/тн-ын дундаж агуулгатай 115 мян.тн зэс молибден, (зэсийн дүйцүүлсэн агуулгыг дунджаар 0.57%), Шивээ толгой нэртэй MV-015226 тоот тусгай зөвшөөрлийн талбайд хамрагдах Хойд Хюгогийн үргэлжлэл хэсгийн эдийн засгийн үр ашигтай бодитой болон боломжтой (В+С) зэргийн нөөцийг 193.980 мян.тн хүдэрт 1.55%-ийн дундаж агуулгатай 3.011 мян.тн зэс, 0.55 гр/тн-ын дундаж агуулгатай 107 тн алт, 4.03 гр/тн-ын дундаж агуулгатай 782 тн мөнгө, (зэсийн дүйцүүлсэн агуулгыг дунджаар 1.90%) тодорхой нөхцөлд эдийн засгийн үр ашигтай бодитой болон боломжтой (В+С) зэргийн нөөцийг 101.551 мян.тн хүдэрт 0.75%-ийн дундаж агуулгатай 765 мян.тн зэс, 0.23 гр/тн дундаж агуулгатай 23 тн алт, 2.03 гр/тн дундаж агуулгатай 207 тн мөнгө (зэсийн дүйцүүлсэн агуулгыг дунджаар 0.57%) нөөцийг тооцсон байна. ЭБМЗ-ийн 2014 оны 10 дугаар

сарын 10-ны өдрийн стр-08/14 тоот дүгнэлтийг үндэслэн гаргасан АМГ-ын даргын 2015 оны 01 дүгээр сарын 14-ны өдрийн Н/10 тоот тушаалаар ашигт малтмалын нөөцийн Улсын нэгдсэн бүртгэлд бүртгэсэн байна." гэж, мөн дүгнэлтийн Ашигт малтмалын газрын даргад уламжлахаар шийдвэрлэсэн хэсгийн 1 дэх хэсэгт: "Өмнөговь аймгийн Ханбогд сумын нутагт орших MV-006709 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй Оюу толгой, MV-015225 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй Жавхлант, MV-015226 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй Шивээ толгой нэртэй Оюу толгойн зэс-алтны бүлэг (Оюут, Хюго Дамметт, Херуга) ордыг ашиглах техник-эдийн засгийн үндэслэл (тодотгол)-ийг хүлээн авах." гэж тус тус дурдсан байна.

5) ЭБМЗ-ийн 2015 оны 9 дүгээр сарын 17-ны өдрийн "Өмнөговь аймгийн Ханбогд сумын нутагт орших MV-006709 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй Оюу толгой, MV-015225 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй Жавхлант, MV-015226 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй Шивээ толгой нэртэй Оюу толгойн зэс-алтны бүлэг (Оюут, Хюго Дамметт, Херуга) ордыг ашиглах техник-эдийн засгийн үндэслэлийн эдийн засгийн хэсгийг хэлэлцсэн тухай" Стр-10/15 дугаартай дүгнэлтийн Ашигт малтмалын газрын даргад уламжлахаар шийдвэрлэсэн хэсгийн 3 дах хэсэгт: "ТЭЗҮ15-ын үйл ажиллагааны зардалд Хөрөнгө оруулалтын гэрээ болон Хувь нийлүүлэгчдийн гэрээнд огт тусгаагүй, Монгол Улсын хууль тогтоомжид байхгүй Онтрэ гоулд ХХК-ийн төлбөрийг \$1.583 саяын дүнгээр оруулсан байна. Тус тохироо болон түүнээс үүдэх зардал нь Оюутолгой төслийн хөрөнгө оруулалтын гэрээнд огт тусгагдаагүй, Монгол Улсын хууль тогтоомжид байхгүй асуудал. Оюу толгой ХХК-ийн мөнгөн урсгалаас хасагдах, Монголын талын өгөөжид сөргөөр нөлөөлөх тус зардлыг ТЭЗҮ15-ын тооцоонд оруулахгүй байх. Цаашид уг асуудлыг хувьцаа эзэмшигчдийн хүрээнд тавьж шийдвэрлүүлэх." гэж дурджээ.

6) 2021 оны 9 дүгээр сарын 20-ны өдрийн ЭБМЗ-ийн хурлаар Оюу Толгойн нөөцийн тодотголыг хэлэлцүүлэн СТР-02-01 дүгээр дүгнэлтийг үндэслэн Үндэсний геологийн албаны даргын 2021 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн Нөөцийг хүлээн авч, бүртгэх тухай тушаалаар "Өмнөговь аймгийн Ханбогд сумын нутагт орших Оюу толгойн зэс-алтны бүлэг ордод 2019 онд гүйцэтгэсэн нөөцийн шинэчилсэн тооцооны үр дүнгийн тайлан"-д тусгагдсан нөөцийг зохиогчдын тооцоолсон 2 дугаар хувилбараар хүлээн авсан. Тухайн ЭБМЗ-ийн дүгнэлтийн 8 дугаарт: Эдгээр хувилбарыг ЭБМЗ-ийн хурлаар хэлэлцүүлж зохиогчдын тооцоолсон 2-р хувилбараар хүлээн авахыг шинжээчид санал болгосон. Зохиогчдын тооцоолсон 2-р хувилбарыг орд тус бүрээр авч үзвэл:

- Хюго Дамметт ордын Хойд Хюго Үргэлжлэл (Шивээ Толгой АТЗ) хэсэгт 1.53% зэсийн эквивалент агуулга бүхий геологийн нөөцийг бодитой болон боломжтой (В+С) зэрэглэлээр 298,844.0 мян.тн хүдэр, үүнд 1.27%-ийн дундаж агуулгатай металлаар 3,797.0 мян.тн зэс, 0.44 г/тн-ын дундаж агуулгатай 130.0 тн алт, 3.31 г/тн-ын дундаж агуулгатай 990.0 тн мөнгө,
- Херуга (Жавхлант АТЗ) хэсэгт 0.64% зэсийн эквивалент агуулга бүхий боломжтой (С) зэрэглэлээр 1,665,710.0 мян.тн хүдрийн геологийн нөөц, үүнд 0.39%-ийн дундаж агуулгатай металлаар 6,542.0 мян.тн зэс, 0.38 г/тн-ын дундаж агуулгатай 629.0 тн алт, 1.40 г/тн-ын дундаж агуулгатай 2,327.0 тн мөнгө, 113.83 г/тн-ын дундаж агуулгатай 190.0 мян.тн молибден, " мөн тухайн дүгнэлтийн 11 дүгээрт: "Цаашид 2015 онд батлагдсан "Ашигт малтмалын баялаг, ордын нөөцийн ангилал, заавар"-ын дагуу геологи хайгуулын ажлыг нэмж хийх, ордын нөөцийн зэрэглэлийг өсгөх, ... "Онтрэ" ХХК-ийн эзэмшиж буй MV-015225, MV-015226 тоот тусгай зөвшөөрлүүдийн асуудлыг шийдвэрлэх,...орд газрыг ашиглах ТЭЗҮ-г эрх бүхий хуулийн этгээдээр хийлгэх, холбогдох хууль тогтоомж, ялангуяа "Ашигт малтмалын тухай" хууль түүнийг хэрэгжүүлэхтэй холбогдон

гарсан заавар журмуудыг мөрдөж ажиллахыг тусгай зөвшөөрөл эзэмшигчид анхааруулахаар тогтов.” гэсэн байна.

Дээрх 2021 онд ЭБМЗ хүлээн авч улсын нөөцөд бүртгүүлсэн ОТ бүлэг ордын геологийн нийт нөөцийг тусгай зөвшөөрөл эзэмшигчээр хуваавал дараах байдалтай байна.

Лиценз эзэмшигч		Агуулагдах метал			
		Зэс (сая.тн)	Алт (тн)	Мөнгө (тн)	Молибден (мян.тн)
Оюу Толгой ХХК		33.2	1,079	8,429	12
Онтрэ ХХК		10.3	759	3,317	190
Нийт		43.5	1,838	11,746	202
Нийт нөөцөд эзлэх Онтрэ ХХК-ийн хувь		24%	41%	28%	94%

Тав. ОТ ХХК ба Антре ресурс лимитэд компани хоорондын хэлэлцээрийн талаар

“Онтрэ” ХХК-ийн эзэмшиж буй ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрлүүд (Жавхлант MV-015225, Шивээ толгой MV-015226)-ийг гэрээний үндсэн дээр ОТ ХХК-д шилжүүлэх хэлэлцээрийг ОТ ХХК болон Антре ресурс лимитэд (АРЛ) компаниуд 2021-2023 онд хийж хэлэлцээрийн үндсэн дээр,

- Ерөнхий гэрээ; (ОТ ХХК, Антрэгийн эдийн засгийн ашиг сонирхлыг баталгаажуулах);
- Борлуулалтын гэрээ (Баяжмалын цэвэр борлуулалтаас бүх зардал, татвар хураамж, менежментийн үйлчилгээний төлбөр, элэгдлийн зардал, холбогдох суутган тооцох татварыг хассан дүнгийн 20% “Онтрэ ресурс” компанид шилжүүлэх);
- Ашигт малтмалын тусгай зөвшөөрлийг шилжүүлэх гэрээ /Жавхлант/;
- Ашигт малтмалын тусгай зөвшөөрлийг шилжүүлэх гэрээ /Шивээ Толгой/ (шилжүүлэх үеийн татварыг ОТ ХХК хариуцах) зэрэг нийт 4 гэрээг байгуулахаар харилцан тохиролцож, гэрээний төслүүдийг эцэслэсэн тухайгаа мэдэгдсэн.

Дээрх хэлэлцээр, гэрээний төслүүдтэй холбогдуулан “Антре ресурс лимитэд” компани нь ОТ ХХК-иас хүлээн авах эдийн засгийн сонирхол (татварын дараах ашиг)-ын 20% хувиасаа 34% хувийг (хийсвэр жишээ: 100\$ тутмын 34\$) нь Монгол тал буюу “Эрдэнэс Оюу Толгой” (ЭОТ) ХХК-д шилжүүлэх зорилгоор байгуулах “Засгийн газрын гэрээ”-ний төслийг 2023 онд ирүүлсэн.

Зургаа. Антре гоулдын хууль зүйн асуудлын талаар

ОТ ХХК ба АРЛ нарын хооронд хийгдсэн хэлэлцээр болон гэрээний төслийг боловсруулахад Монголын тал, түүнд дотроо ЭОТ ХХК-ийн оролцоо хангагдаагүй бөгөөд харин хэлэлцээрийн талаарх мэдээллийг ирүүлж байсан. Дурдан буй талуудын хооронд хийгдсэн хэлэлцээр, тохирсон гэрээний төсөл дэх санхүүгийн тооцоолол, үзүүлэлтүүд нь ХөОГ-ний “татварын тогтворжуулсан” нөхцөлөөр илэрхийлэгдсэн бөгөөд “Онтрэ” ХХК-ийн тусгай зөвшөөрлийг нэгэнт ХөОГ-ний үйлчлэлд хамруулсан мэтээр тодорхойлогджээ. Үүнийг дор дурдсан болон энэхүү мэдээлэл-танилцуулгын бусад хэсэгт дурдсан үндэслэлээр хүлээн зөвшөөрөх боломжгүй юм. Тухайлбал,

- 1) ХөОГ-ний 1.5-д “Энэхүү Гэрээ нь Гэрээт талбайд ашигт малтмал эрэх, хайх, газрын гадаргуу болон түүний хэвлийгээс ашигт малтмал ялган авах, олборлох, түүнчлэн тээвэр, эрчим хүч, усны болон бусад дэд бүтцийг барьж байгуулах, тэдгээрийг ажиллуулах, хүдэр боловсруулах /бутлах, тээрэмдэх, хөвүүлэн

- баяжуулах, шүүх г.м/, бүтээгдэхүүн үйлдвэрлэх, борлуулах, уурхайг хаах, байгаль орчны нөхөн сэргээлт хийх, хүдрийн овоолго, хог, хаягдлын асуудлыг шийдвэрлэх зэрэг Оюу толгой төсөлтэй холбоотой Хөрөнгө оруулагчийн бүхий л төрлийн үйл ажиллагаанд /цаашид "Үндсэн үйл ажиллагаа" гэх/ хамаарна" гэж гэрээний үйлчлэх хүрээг тодорхойлсон;
- 2) ХөОГ-ний 16.11-д "гэрээт талбай гэж" 16.11.1-д "ашиглалтын 6709А, 6708А болон 6710А тоот тусгай зөвшөөрлөөр олгосон талбайг"; мөн 16.11.2-т "Энэхүү Гэрээний 15.5-д заасны дагуу гэрээнд хамааруулсан Ашиглалтын тусгай зөвшөөрлүүдэд хамаарах бусад нэмэлт талбай болон бусад эдэлбэр"-ийг хамааруулан тогтоосон. Түүнчлэн, гэрээний 16.25-д зааснаар Хөрөнгө оруулагчийг тодорхойлохдоо ашигт малтмалын ашиглалтын 6708А, 6709А болон 6710А дугаар тусгай зөвшөөрлүүдийн эзэмшигчийг ойлгох бөгөөд гэрээний 16.31-д Монгол Улсын Ашигт малтмалын тухай хуулийн дагуу олгогдсон 6709А, 6708А болон 6710А дугаар ашигт малтмал ашиглалтын тусгай зөвшөөрлүүд хамаарах бөгөөд гэрээний 15.7.8-д заасан ашиглалтын тусгай зөвшөөрлүүд болон энэхүү Гэрээний 15.5-д заасны дагуу бусад эдэлбэр газрыг хамруулсан;
- 3) ХөОГ-ний 15.5-д Хөрөнгө оруулагч нь геологи, уул уурхайн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад бичгээр мэдэгдэл хүргүүлж, Хөрөнгө оруулагчийн шууд ба шууд бусаар эзэмшиж буй, эсхүл хяналтдаа авсан Оюу толгой ордын эрдэсэжсэн тогтолцооны хэсэг болох ашигт малтмалыг агуулж байгаа ашиглалтын тусгай зөвшөөрлүүдийг тус гэрээнд хамааруулах хүсэлтээ гаргах эрхтэй ба уг хүсэлтийг Засгийн газар нь Хөрөнгө оруулалтын гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах замаар шийдвэрлэхээр заасан. Мөн гэрээний 15.30-д "Талууд бичгээр харилцан тохиролцсоны үндсэн дээр энэхүү Гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулж болно" гэсэн нөхцөлийг тусгасан;
- 4) Дээрхээс үзвэл ХөОГ-ний үйлчлэх хүрээнд 6709А, 6708А болон 6710А дугаар ашигт малтмал ашиглалтын тусгай зөвшөөрлүүд, түүний эдэлбэр газар хамаарахаар тусгасан байна. Харин "Онтрэ" ХХК-ийн эзэмшиж байгаа ашигт малтмалын ашиглалтын MV-015225, MV-015226 дугаар тусгай зөвшөөрлүүд нь ХөОГ-ний үйлчлэх хүрээнд хамаарахгүй юм.

"Онтрэ" ХХК-ийн тусгай зөвшөөрлүүдийг ОТ ХХК-д шилжүүлэх тохиолдолд тэдгээр тусгай зөвшөөрлүүдийг төслийн санхүүжилтээр хүлээсэн үүргийн гүйцэтгэлийг хангах баталгаа болгож **"Тусгай зөвшөөрлүүдийг барьцаалуулах"** тогтоолын төслүүдийг батлуулах асуудал тусгасаар ирсэн. Энэхүү барьцааны асуудал нь,

- Монгол Улсын Үндсэн хуулийн Зургаадугаар зүйлийн 2-т: *"Монгол Улсын иргэдэд өмчлүүлснээс бусад газар, түүнчлэн газрын хэвлий, түүний баялаг ... төрийн өмч мөн"* гэж, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.4-т: *"төрийн өмчийг барьцаалах, орон нутгийн өмчид шилжүүлэх тухай шийдвэр гаргах;"* нь Монгол Улсын Их Хурлын шийдвэрлэх бүрэн эрхийн асуудал байхаар хуульчлагдсантай нийцэхгүй;
- Оюу Толгой төслийн Хөрөнгө оруулалтын гэрээ, Хувь нийлүүлэгчдийн гэрээ (нэмэлт, өөрчлөлт оруулж дахин тодотгосон)-нд төсөл хэрэгжүүлэгч ОТ ХХК-д стратегийн ач холбогдол бүхий ордын ашигт малтмалын тусгай зөвшөөрлүүдийг барьцаалах эрхийг олгоогүй, тийм агуулга бүхий хэлэлцээр-тохиролцоонд Талууд хүрээгүй;
- Монгол Улсын Их Хурлын 2021 оны "Оюу толгой ордоос Монгол Улсын хүртэх үр ашгийг нэмэгдүүлэх арга хэмжээний тухай" 103 тогтоолын 1.2-т заасны дагуу Оюу Толгойн Далд уурхайн бүтээн байгуулалт, санхүүжилтийн төлөвлөгөө (ДУББСТ), Далд уурхайн бүтээн байгуулалт, санхүүжилтийн

нэмэлт төлөвлөгөө (ДУББСНТ)-г цуцалж, хүчингүй болгох мэдэгдлээ түүнийг байгуулсан Талууд харилцсан солилцсон, тиймээс "Дубай"-н гэрээний үйлчлэлийг сэргээн ашиглах явдлыг хүлээн зөвшөөрөх боломжгүй зэрэг үндэслэлээр Антре (Онтрэ)-ийн тусгай зөвшөөрлүүдийг ОТ ХХК-д шилжүүлэх тохиолдолд тэдгээрийг барьцаалах асуудлыг дэмжих хууль зүйн боломжгүй юм.

Хэрэв "Онтрэ" ХХК-ийн тусгай зөвшөөрлүүдийг ОТ ХХК-д шилжүүлэх тохиолдолд ХөОГ-ээр тохиролцсон (ХөОГ-ний 15.5)-ы дагуу Засгийн газарт хүсэлтээ бичгээр хүргүүлж, нэмэлт, өөрчлөлт оруулах эсэх асуудлыг харилцан тохиролцон холбогдох шийдвэрийг гаргуулах шаардлагатай.

Антрегийн хууль зүйн асуудал, үр дагавар, түүнчлэн тооцоолол, эрсдэл, хувилбаруудын талаар ЭОТ ХХК-иас толгой компани "Эрдэнэс Монгол" ХХК (ЭМГЛ), түүний ТУЗ, Ерөнхий сайдын захирамжаар байгуулагдсан "Ажлын хэсэг", "Ажлын дэд хэсэг"-үүд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газар (ЗГХЭГ), Засгийн газарт мэдээлэл, танилцуулгыг хийсээр ирж, албан бичгээр мэдээлэл хүргүүлж, асуудлыг хэрхэн шийдвэрлэх талаар чиглэл хүссэн боловч өнөөдрийн байдлаар тодорхой хариу, шийдвэр, чиглэл хараахан гараагүй байна.

Долоо. Антре гоулдын асуудлыг шийдвэрлэх урьдчилсан нөхцөлийн талаар

Ашигт малтмалын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.4 дэх хэсэгт заасны дагуу Монгол Улсын Их Хурлын 2007 оны 27 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар "Оюу Толгой" бүлэг ордыг Монгол Улсын стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордод хамруулсан.

2006 оны 7 дугаар сарын 08-ны өдөр батлагдсан Ашигт малтмалын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1 дэх хэсэгт Хөрөнгө оруулалтын гэрээг тусгай зөвшөөрөл эзэмшигчтэй байгуулахаар зохицуулсан бөгөөд уг зохицуулалтын хүрээнд 2009 оны 10 дугаар сарын 06-ны өдөр Монгол Улсын Засгийн газар болон Айвенхоу Майнз Монголиа Инк ХХК, Айвенхоу Майнз Лимитед, Рио Тинто Интернэшнл Холдингс Лимитед нарын хооронд Хөрөнгө оруулалтын гэрээг байгуулсан. Харин Антре ресурс лимитэд компани нь хараахан "Хөрөнгө оруулалтын гэрээ"-г байгуулсан тал биш, уг гэрээний үйлчлэлд түүний охин компани болох "Онтрэ" ХХК-ийн эзэмшиж буй ашигт малтмалын тусгай зөвшөөрөл ХөОГ-ний 1.5, 15.5, 16.11, 16.11.1, 16.11.2, 16.25, 16.31-д зааснаар хамаарахгүй юм.

Засгийн газрын 2025 оны 4 дүгээр сарын 09-ний өдрийн хуралдаанаар Ашигт малтмалын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.12 дахь заалтад зааснаар стратегийн ач холбогдол бүхий Оюу толгой бүлэг ордын талбайн хил заагийг тогтоох асуудлыг хэлэлцүүлээд байна.

Засгийн газраас стратегийн ач холбогдол бүхий Оюу толгой бүлэг ордын талбайн хил заагийг хэрхэн тогтоох, түүнд "Онтрэ" ХХК-ийн эзэмшиж буй тусгай зөвшөөрлүүд хамаарах эсэхээс шалтгаалан Монголын талын хүртэх өгөөж харилцан адилгүй ялгаатай тооцогдохоор байна.

"Онтрэ" ХХК-ийн эзэмшиж буй тусгай зөвшөөрлүүдийг стратегийн ач холбогдол бүхий ордод хамруулж талбайн хил заагийг тогтоох тохиолдолд,

- 1) Юуны түрүүнд Ашигт малтмалын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.5 дахь хэсэг, мөн хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.7 дахь заалтын дагуу тусгай зөвшөөрөл эзэмшигч ("Онтрэ" ХХК)-ийн тухайн ордод оруулсан хөрөнгийн 34 хүртэлх хувьтай тэнцэх хувьцааг төр үнэ төлбөргүйгээр эзэмших, эсхүл түүнийг ашигт малтмалын ордын ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрөөр орлуулах эсэх

шийдвэрийг Засгийн газраас өргөн мэдүүлснээр эсхүл Монгол Улсын Их Хурлаас өөрөө санаачлан тогтооно;

- 2) УИХ-аас гаргах шийдвэрээс хамаарч тусгай зөвшөөрөл эзэмшигч компанид төр хувь эзэмших үү? эсхүл түүнийг АМНАТ-аар орлуулах уу? гэдэг асуудал тодорхой болно.

Харин "Онтрэ" ХХК-ийн эзэмшиж буй тусгай зөвшөөрлүүдийг стратегийн ач холбогдол бүхий ордод хамруулахгүйгээр талбайн хил заагийг тогтоох тохиолдолд Антре гоулдын асуудлаар Ашигт малтмалын тухай хуулийн "ердийн" зохицуулалт үйлчилнэ. Гэтэл ОТ ХХК нь "Онтрэ" ХХК-ийн тусгай зөвшөөрлийг нэгэнт ХөОГ-ний үйлчлэлд хамруулсан мэтээр тодорхойлдог.

Хэрэв "Онтрэ" ХХК-ийн тусгай зөвшөөрлүүдийг ОТ ХХК-д шилжүүлэх тохиолдолд ХөОГ-гээр тохиролцсон (ХөОГ-ний 15.5)-ы дагуу Засгийн газарт хүсэлтээ бичгээр хүргүүлж, нэмэлт, өөрчлөлт оруулах эсэх асуудлыг харилцан тохиролцон холбогдох шийдвэрийг гаргуулах шаардлагатай.

Засгийн газраас ХөОГ-нд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудал нь ХөОГ-ний үйлчлэх хүрээг өргөжүүлэх үр дагавартай тул Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлийн 2 дахь хэсгийн 7 дахь заалт, Татварын ерөнхий хуульд зааснаар татварын хувь, хэмжээг Улсын Их Хурал тогтоох бөгөөд түүний эрх олгосноор Засгийн газар тогтоож болохоор тусгасан тул УИХ-тай зөвшилцөх шаардлагатай. Иймээс АМНАТ болон татварын хувь, хэмжээг тогтворжуулах асуудлыг Улсын Их Хурлаар шийдвэрлүүлэх шаардлагатай.

"Онтрэ" ХХК-ийн тусгай зөвшөөрлүүдийг ОТ ХХК-д шилжүүлэх хэлцэлд Монгол Улсын Үндсэн хуулийн Зургаадугаар зүйлийн 2 дахь хэсэгт "Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордыг ашиглахдаа байгалийн баялаг ард түмний мэдэлд байх зарчимд нийцүүлэн түүний үр өгөөжийн дийлэнх нь ард түмэнд ногдож байх..." гэж заасан шаардлагыг хангуулах асуудлыг судлан үзсэний үндсэн дээр дээрх шийдвэрүүдийг гаргах хууль зүйн орчин бүрдэнэ. Өөрөөр хэлбэл, Антрегийн талбайгаас хүртэх өгөөжийн 51%-иас доошгүйг Монголын тал хүртэх зарчимд суурилна.

Найм. Антре гоулдын талаар ЭОТ ХХК-иас хэрэгжүүлсэн ажлын талаар

Ялангуяа Монгол Улсын Их Хурлын 2021 оны "Оюу толгой ордоос Монгол Улсын хүртэх үр ашгийг нэмэгдүүлэх тухай" 103 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангуулах, Оюу Толгой төслийн гадаадын хөрөнгө оруулагч талтай хэлэлцээ хийх, төслийг тохирох, эцэслэсэн хувилбарыг Засгийн газрын хуралдаанд танилцуулах үүрэг бүхий Монгол Улсын Ерөнхий сайдын 2024 оны 120 дугаар захирамжаар шинэчлэн байгуулагдсан "Ажлын хэсэг"-т Антре гоулд (Онтрэ)-ын асуудлаар:

- 2023 оны 11 дүгээр сарын 09-ний өдрийн 01/245 дугаартай "Санал, хүсэлт хүргүүлэх тухай" албан бичгээр Ажлын хэсгийн дарга, Монгол Улсын сайд, ЗГХЭГ-ын даргад;
- 2023 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн 01/266 дугаартай "Асуудал шийдвэрлүүлэх хүсэлт гаргах тухай" албан бичгээр Ажлын хэсгийн нарийн бичгийн дарга, "Эрдэнэс Монгол" ХХК-ийн Гүйцэтгэх захиралд;
- 2024 оны 4 дүгээр сарын 11-ний өдрийн 01/72 дугаартай "Мэдээлэл, хүсэлт хүргүүлэх тухай" албан бичгээр Ажлын хэсгийн дарга, Монгол Улсын сайд, ЗГХЭГ-ын даргад;
- 2024 оны 5 дугаар сарын 08-ны өдрийн 01/98 дугаартай "Мэдээлэл хүргүүлж, чиглэл хүсэх тухай" албан бичгээр Ажлын хэсгийн дарга, Монгол Улсын сайд, ЗГХЭГ-ын даргад;

- 2024 оны 9 дүгээр сарын 27-ны өдрийн 01/220 дугаартай "Мэдээлэл хүргүүлэх тухай" албан бичгээр Ажлын хэсгийн дарга, Монгол Улсын сайд, ЗГХЭГ-ын даргад;
- 2024 оны 10 дугаар сарын 03-ны өдрийн 01/224 дугаартай "Мэдээлэл хүргүүлэх тухай" албан бичгээр Ажлын хэсгийн дарга, Монгол Улсын сайд, ЗГХЭГ-ын даргад;
- 2024 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн 01/245 дугаартай "Мэдээлэл хүргүүлэх тухай" албан бичгээр Ажлын хэсгийн дарга, Монгол Улсын сайд, ЗГХЭГ-ын даргад хандаж мэдээлэл хүргүүлж, чиглэл хүсээд байна.

Түүнчлэн дээрх "Ажлын хэсэг"-т Оюу Толгой төслийн хүрээнд нэн тулгамдсан асуудлуудын нэг болох "Антре гоулд (Онтрэ)"-ын ашиглалтын тусгай зөвшөөрлийг "Оюу Толгой" ХХК-д шилжүүлэхтэй холбоотой гэрээнүүдийн төсөл, энэ талаарх хувилбарууд, түүнээс үүдэн гарах үр дагавар, тооцоолол, арбитрын маргааны тухай мэдээлэл-танилцуулгыг ЭОТ ХХК-иас 2024.03.26, 2024.04.02, 2024.08.09-ний өдөр тус тус танилцуулж, холбогдох чиглэл хүссэн.

Мөн Ерөнхий сайдын 2024 оны 120-р захирамжаар шинэчлэн байгуулагдсан Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайдын ахалсан Ажлын хэсгийн нарийн бичгийн дарга АҮЭБЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга болон тус яамны газар, хэлтсийн дарга нарт "Эрдэнэс Оюу Толгой" ХХК-иас боловсруулсан УИХ-ын 2021 оны 103 дугаар тогтоолын хэрэгжилт, Хувьцаа эзэмшигчдийн зээлийн хүү бууруулах, Антрегийн гоулд, ОТТЭЗҮ-ийн тодотголын талаар холбогдох мэдээлэл, танилцуулгыг 2024.12.10-ны өдөр танилцуулсан.

Түүнчлэн Ерөнхий сайдын захирамжаар байгуулагдсан "Ажлын хэсэг"-ийн даргын тушаалаар байгуулагдсан "Ажлын дэд хэсэг"-үүдэд Антре гоулд (Онтрэ)-ын асуудалтай холбогдуулан:

- Уул уурхайн сайд, Ажлын дэд хэсгийн даргад: "...*Ашигт малтмалын тухай хуулийн 9 дүгээр зүйл. Засгийн газрын бүрэн эрх 9.1.12. "стратегийн ач холбогдол бүхий ордын талбайн хил заагийг тогтоох;"* гэсний дагуу "Антре гоулд (Онтрэ)-ын асуудал"-аар тодорхой санал, дүгнэлт гаргаж, Ажлын хэсэгт танилцуулж, шийдвэрлүүлж өгөх" хүсэлтийг "Эрдэнэс Оюу Толгой" ХХК-ийн Гүйцэтгэх захирлын 2023 оны 11 дүгээр сарын 22-ны өдрийн 01/259 дугаартай "Хүсэлт хүргүүлэх тухай" албан бичгээр;
- Сангийн сайд, Ажлын дэд хэсгийн даргад: "...Монголын талын хүртэх өгөөжийн хувилбаруудыг санхүүгийн тооцоололд үндэслэн боловсруулж, Хөрөнгө оруулалтын гэрээний татварын нөхцөл, тэдгээрийн хөнгөлөлт, чөлөөлөлтөд хамаарах эсэх талаар тодорхой санал, дүгнэлт гаргаж, Ажлын хэсэгт танилцуулж, шийдвэрлүүлж өгөх" хүсэлтийг "Эрдэнэс Оюу Толгой" ХХК-ийн Гүйцэтгэх захирлын 2023 оны 11 дүгээр сарын 22-ны өдрийн 01/260 дугаартай "Хүсэлт хүргүүлэх тухай" албан бичгээр тус тус хүргээд байна. улмаар үл ойлголцол, маргаан, ХөОГ-нд тусгагдсан арбитрын маргааны эхлэл болох бодит эрсдэл, үндэслэлтэй;
- Оюу Толгой төслийн гадаадын хөрөнгө оруулагч талтай яриа хэлэлцээ хийж буй Монгол Улсын Ерөнхий сайдын 2024 оны 120 дугаар захирамжаар шинэчлэн байгуулагдсан "Ажлын хэсэг"-ээс ОТ-Антре хоорондын ба Монгол Улсын Засгийн газар-Антре хоорондын хэлцлийг цогцоор нь болон тусгайлан хэрхэн батлах талаарх уулзалт, хурлууд идэвхтэй, тасралтгүй үргэлжилсээр байгаа, энэ талаар баримтлах тодорхой шийдвэр, чиглэл албажиж гараагүй байгаа зэрэг болно.

Гэвч ОТ ХХК болон Туркойз Хилл Ресурс Лтд ("ТХР")-ын эсрэг Антре Ресурс Лимитед ("АРЛ")-ээс гаргасан арбитрын нэхэмжлэлтэй холбогдуулан олон улсын арбитрын бүрэлдэхүүн хэсэгчилсэн эцсийн шийдвэрээ 2024 оны 12 дугаар сарын 19-ний өдөр гаргасантай холбогдуулан түүний хэрэгжилтийг хангуулахаар ОТ ХХК-ийн ТУЗ нь 2025 оны 1-р сард "Хөрөнгө оруулалтын гэрээ" байгуулагдахаас өмнө талуудын хооронд тохиролцсон "Хамтран ажиллах гэрээ"-г болон "Тусгай зөвшөөрөл шилжүүлэх гэрээ (Шивээ толгой, Жавхлант)"-г байгуулах эрхийг гүйцэтгэх удирдлагадаа саналын давуу эрх (Рио Тинто 6 vs Монгол 3)-ээр олгоод байна.

Ес. Антре гоулдын асуудлаар яриа хэлэлцээний явцын талаар

Монгол Улсын Их Хурлын 2021 оны "Оюу толгой ордоос Монгол Улсын хүртэх үр ашгийг нэмэгдүүлэх арга хэмжээний тухай" 103 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх ажлыг удирдан зохион байгуулах, гадаадын хөрөнгө оруулагч талтай яриа хэлэлцээр хийх, төслийг тохирох, эцэслэсэн хувилбарыг Засгийн газрын хуралдаанд танилцуулах үүрэг бүхий "Ажлын хэсэг"-ийг Монгол Улсын Ерөнхий сайдын 2024 оны 120 дугаар захирамжаар шинэчлэн байгуулж, түүнийг Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд Ц.Туваан ахалж, Тэргүүн шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд, Шадар сайд, Хууль зүй дотоод хэргийн сайд, Сангийн сайд, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд, Эрчим хүчний сайд, бусад төрийн байгууллагын төлөөлөл бүхий 13 хүний бүрэлдэхүүнтэйгээр ажиллаж байна.

Тус "Ажлын хэсэг" нь Антре гоулдын асуудлыг хариуцан ажиллаж байгаа бөгөөд өнгөрсөн хугацаанд тус "Ажлын хэсэг" хоёр удаа хуралдаж, түүгээр,

- 1) УИХ-ын 2021 оны 103-р тогтоолын хэрэгжилт;
- 2) "Антре гоулд"-ын асуудал;
- 3) Хувь нийлүүлэгчдийн зээлийн хүүг бууруулах асуудал;
- 4) Татварын арбитрын маргааны талаар хэлэлцээр хийх тухай гадаадын хөрөнгө оруулагч талаас ирүүлсэн саналын талаар тус тус мэдээлэл сонслоо.

Энэхүү мэдээлэл-танилцуулгыг хүргүүлэх огноонд "Ажлын хэсэг"-ээс Антре гоулдын талаар нэгдсэн санал дүгнэлтээ гаргаагүй, судалгаа, яриа хэлэлцээрийн ажил үргэлжилж байна.

Асуулт 2.

"Дээр дурдсан яриа хэлэлцээний үр дүнд Монгол Улсын эрх ашгийг хангуулах зорилтын хүрээнд Оюу Толгойн бүлэг ордыг ашиглах санхүүгийн тооцоолол, энгийн хувьцааны эзэмшил, тусгай АМНАТ зэрэг боломжит бүх хувилбарууд дээр санхүү, эдийн засгийн тооцоолол хийсэн эсэх, энэ талаарх санхүүгийн тооцоолол, судалгаа,"

ЭОТ ХХК-ийн хариулт:

Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны 3 сарын 25-ны өдрийн А/46 тоот тушаалаар "Онтрэ" ХХК-ийн MV-015225, MV-015226 тоот ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбайгаас Монголын талын хүртэх өгөөжийн талаарх санхүүгийн тооцоолол, хувилбаруудыг судалж, санал боловсруулж танилцуулах "Ажлын дэд хэсэг"-ийг Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам, Эдийн засаг, хөгжлийн яам, Ашигт малтмал, газрын тосны газар болон ЭОТ ХХК-ийн бүрэлдэхүүнтэйгээр байгуулагдан ажиллаж байна. ЭОТ ХХК-ийн зүгээс "Онтрэ" ХХК-ийн ашиглалтын талбайд хамаарах,

- Хувьцаа эзэмшил, тусгай АМНАТ, өсөн нэмэгдэх АМНАТ зэрэг боломжит хувилбаруудыг багтаасан санхүүгийн тооцооллуудыг 2025 оны 4-р сарын 14-ны өдрийн "Ажлын дэд хэсэг"ийн 3-р хуралдаанд танилцуулсан.

Танилцуулгад өгөөжийн тодорхойлолтыг тусгаж, Монголын тал, хөрөнгө оруулагч талуудын өгөөжийн харьцааг тооцон гаргасан. Үүнд "Онтрэ" ХХК-ийн Оюу толгой бүлэг ордын хэмжээнд үзүүлэх нөлөөг тооцон оруулсан.

- Ойрын хугацаанд ажлын дэд хэсгийн хуралдаанаар Монголын талын өгөөжийг 51% хувиас дээш байх боломжит хувилбаруудыг эцэслэн сонгох, "Ажлын дэд хэсэг"-ийн дүгнэлтийг Монгол Улсын Ерөнхий сайдын 120 дугаар захирамжаар байгуулагдсан "Ажлын хэсэг"-т хүргүүлэхээр төлөвлөн ажиллаж байна.

Асуулт 3.

"Монгол Улсын Засгийн газар Оюу Толгой ХХК-д эзэмшиж буй энгийн хувьцааны 34 хувийн өнөөгийн үнэ цэнийг хэрхэн тооцоолсон, энэхүү хувь эзэмшилд эхний ногдол ашгийг хэзээ, ямар дүнгээр хуваарилах, мөн энэхүү үнэлгээнд Онтрэ ХХК-ийн эзэмшилд буй ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбайд хамаарах нөөц, баялгаас Монгол Улсад ногдох хувь хэрхэн нөлөөлөх талаарх дэлгэрэнгүй тооцоолол бүхий судалгааны мэдээлэл;"

ЭОТ ХХК-ийн хариулт:

ОТ ХХК-ийн ТЭЗҮ2023-т үйлдвэрлэлийн нөөц хувилбар (reserve case)-т суурилсан эдийн засгийн үр ашгийг 10%-ийн хорогдуулалттай үнэ цэнээр тооцоход, ОТ төслийн нийт өнөөгийн үнэ цэнэ 12,520 сая ам.доллар байх төсөөлөлтэй байна (Онтрэ-н тусгай зөвшөөрөл орсноор). ОТ ХХК-ийн санхүүгийн загварчлалд 2037 оноос эхлэн төслөөс ногдол ашиг хуваарилахаар төлөвлөснийг доорх хүснэгтэд харуулав.

Монгол Улсын Засгийн газрын хувь эзэмшилд ногдох ногдол ашиг,
(сая ам.доллар), "Онтрэ" ХХК-ийг хамруулснаар

2029	2030	2031	2032	2033	2034	2035	2036
-	4.0	20.0	36.0	60.4	37.9	8.6	-
2037	2038	2039	2040	2041	2042	2043	2044
36.1	540.9	688.6	433.9	348.1	94.4	70.0	15.1
2045	2046	2047	2048	2049	2050	2051	Нийт
101.0	159.0	-	-	-	129.4	92.0	2,875.3

Монгол Улсын Засгийн газрын хувь эзэмшилд ногдох ногдол ашиг,
(сая ам.доллар), "Онтрэ" ХХК-ийг хамруулахгүйгээр

2037	2038	2039	2040	2041	2042	2043	2044
-	-	370.9	433.9	348.1	94.4	70.0	15.1
2045	2046	2047	2048	2049	2050	2051	Нийт
101.0	159.0	-	-	-	129.4	92.0	1,813.8

ЭБМЗ-р хэлэлцүүлэхээр хүргүүлсэн ОТ ТЭЗҮ2023 төсөл нь зөвхөн Хойд Хюго 1 давхрын түвшинд хийгдсэн бөгөөд уг ТЭЗҮ-д "Онтрэ" ХХК-ийн талбайн Хойд Хюго 1 давхарт хамаарах хэсгийн санхүүгийн тооцоолол туссан. Хэрэв 10%-ийн хорогдуулалттай тооцвол "Онтрэ" ХХК-ийн Хойд Хюгогийн нийт өнөөгийн үнэ цэн 844 сая ам.доллар болно. Уурхайн ашиглалтын хугацаа (2026-2037 он)-д 37.8 сая тонн хүдэр олборлох төлөвлөгөөтэй бөгөөд 2030 оноос хөрөнгө оруулагч талуудад ногдол

ашиг тараах төсөөлөлтэй. ОТ бүлэг ордоос Монголын талын 34%-д ногдох ногдол ашиг 1.8 тэрбум ам.доллар байна.

Асуулт 4.

"Монгол Улсын Татварын ерөнхий газраас Оюу Толгой ХХК-д 2013-2015 онд 377.1 тэрбум, 2016-2018 онд 649.0 тэрбум, 2019-2020 онд 279.0 тэрбум буюу нийт 1.3 их наяд төгрөгийн нөхөн татвар, торгууль, алданги ноогдуулсан. Харин 2025 оны 01 дүгээр сарын 22-ны өдөр Австралийн "Financial Review" сонинд "Рио Тинто компани нь Монгол Улсын Засгийн газарт татварын маргааны асуудлыг 295.0 сая ам.доллар буюу 814.0 тэрбум төгрөгт багтаан шийдвэрлэхээр санал болгосон" талаар мэдээлсэнтэй холбогдуулан уг татварын маргааны явц болон Рио Тинто компаниас ирүүлсэн саналын талаар дэлгэрэнгүй мэдээлэл;"

ЭОТ ХХК-ийн хариулт.

Татварын маргааны явцын талаар

ОТ ХХК-ийн нэхэмжлэлтэй, Монгол Улсын Засгийн газарт холбогдох татварын маргаан, түүнийг Лондонгийн арбитраар хянан шийдвэрлэх ажиллагаатай холбогдуулан Монгол Улсын Ерөнхий сайдын 2024 оны 9 дүгээр сарын 18-ны өдрийн 65 дугаар захирамжаар "Ажлын хэсэг"-ийг шинэчлэн байгуулан ажиллаж байна.

Монгол Улсын Ерөнхий сайдын захирамжаар байгуулагдсан өмнөх ба одоогийн "Ажлын хэсэг"-үүд нь татварын маргаан, түүнийг арбитраар журмаар шийдвэрлүүлэхтэй холбогдуулан Монгол Улсын Засгийн газарт гэрээний үндсэн дээр зөвлөх үйлчилгээ үзүүлэгч "Herbert Smith Freehills" фирмтэй 2023 оны 8 дугаар сараас хойш хамтран ажиллаж байна.

Арбитрын хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцын хувьд 2025 оны 01 дүгээр сард талууд арбитраар бүрэлдэхүүнээс шийдвэр гаргуулах нотлох баримтуудыг гарган өгч, одоо хариу тайлбарууд хүргүүлэх ажиллагаа хийгдэж байна. "Ажлын хэсэг"-ээс өгсөн урьдчилсан мэдээллээр арбитраар маргааныг хянан шийдвэрлэх хурал 2025 оны 9 дүгээр сарын 15-26-ны хооронд болох урьдчилсан тов гарчээ.

Рио Тинто компаниас ирүүлсэн саналын талаар

Рио Тинто компанийн Зэсийн группийн Гүйцэтгэх захирал Кэйти Жаксон-оос 2024 оны 12 дугаар сарын 19-ний өдөр Аж Үйлдвэр, Эрдэс Баялгийн сайд буюу Монгол Улсын Ерөнхий сайдын 2024 оны 120 дугаар захирамжаар байгуулагдсан "Ажлын хэсэг"-ийн ахлагч Ц.Туваанд татварын маргааныг шийдвэрлэхтэй холбогдуулан албан бичгээр тодорхой саналуудыг ирүүлсэн.

Тус албан бичигт: "ОТ ХХК нь 2013-2020 оныг хамарсан Татварын нөхөн ногдуулалтын актуудаар ногдуулсан маргаантай байгаа **840 тэрбум** төгрөгийн нөхөн татварын дүнг нэхэмжлэх эрхээсээ татгалзаж буулт хийхэд бэлэн байна. Гэхдээ ОТ ХХК нь холбогдох гэрээ болон хууль тогтоомжийн дагуу төлбөл зохих бүхий л татвараа төлсөн гэж үзэж байгаа тул тогтоосон торгууль, алдангийн дүн болох **445 тэрбум** төгрөгийг хүлээн зөвшөөрөхөд нэн хүндрэлтэй байна" гэж дурджээ.

Мөн арбитраар маргааны хүрээнд хүлээн зөвшөөрч байгаа болон хүлээн зөвшөөрөхгүй байгаа асуудлуудын талаарх байр сууриа илэрхийлсэн байна. Гэвч хүлээн зөвшөөрч байгаа дийлэнх асуудлууд нь өнгөрсөн хугацаанд гарсан төлбөрийг хүлээн зөвшөөрч байгаа болохоос тухайн татварыг тооцож байгаа аргачлалыг хүлээн зөвшөөрөөгүй агуулгатай байна.

Уг асуудалтай холбогдуулан Рио Тинто компанийн Зэсийн группийн Гүйцэтгэх захирал Кэйти Жаксон-с ирүүлсэн албан бичгийг хавсралтаар хүргүүлж байна.

“Олон улсын үнэ шилжилтийн механизм (“transfer pricing”)-аар дамжуулж, үндэстэн дамнан татвараас зайлсхийх явдалтай тэмцэх хүрээнд оффшор бүсэд тооцогдох Нидерландын Вант Улстай давхар татварын хэлэлцээрийг 2012 оны 11 дүгээр сарын 28-ны өдөр цуцалсан. Харин 2023 оны 12 дугаар сард Оюу Толгой ХХК нь Нидерландын Вант Улсад бүртгэлтэй толгой компаниа Монгол Улстай давхар татварын хэлэлцээртэй Сингапур Улс руу шилжүүлсэн байна. Үүнтэй холбогдуулан, үнэ шилжилтийн механизмаар татвараас зайлсхийх эрсдэлийг дахин үүсгэхгүй байх хүрээнд авч хэрэгжүүлж буй урьдчилан сэргийлэх арга хэмжээний талаарх мэдээлэл болон цаашид Оюу Толгой ХХК Монгол Улсад шударгаар татвар төлөх суурь нөхцөл бүрдсэн эсэх талаарх мэдээлэл;”

Дээрх асуултад холбогдох арга зүйн зөвлөгөө мэдээлэл өгөх, урьдчилан сэргийлэх, хяналт шалгалтыг хэрэгжүүлэх чиг үүргийг хуулиар Татварын ерөнхий газар, түүний бүтцийн тодорхой нэгж хариуцаж байгаа тул энэ асуултад холбогдох мэдээллийг Татварын ерөнхий газраас албан бичгээр хандаж гаргуулан авч, хариуг ирүүлмэгц Танд дахин шуурхай хүргүүлье.

“Оюу Толгой ХХК-ийн санхүүгийн тайланд тусгагдсан 18.0-20.0 орчим тэрбум ам.долларын нийт өрийн хэдэн хувь нь харилцан хамаарал бүхий этгээд буюу толгой компани болох Рио Тинто компанид хуваарилагдаж буй болон мөн уг өрийн үүссэн нөхцөл, хүүгийн төлбөр хэдэн ам. доллароор /төгрөгөөр/ тус тус тооцогдож буй талаарх дэлгэрэнгүй мэдээлэл;”

Уг өрийн үүссэн нөхцөл нь ОТ ХХК нь шаардлагатай мөнгөн хөрөнгийг санхүүжүүлэх зохицуулалтыг НӨОДТХНГ-ний 9.2-д заасны дагуу санхүүжүүлэх ба үүнд энгийн хувьцаа болон хувь нийлүүлэгчдийн зээл хамаарна. Мөн ААНОАТ-ын тухай хуулийн 14.3 болон ХөОГ-ний 2.31-д тус тус заасны дагуу зээл, хөрөнгө оруулалтын харьцааг 3:1-ээр 2010-2021 онуудад хадгалж ирсэн. Энэ асуудлыг доорх хүснэгтүүдээр харуулав.

Шугаргагч үйлдвэр, хөрөнгө, хэрэгсэл (Г/р/р/л)	2010-2011
Хөрөнгө оруулалтын мөнгөн урсгал	(16.1)
Үйл ажиллагааны мөнгөн урсгал	1.4
Санхүүжилтийн мөнгөн урсгал	(5.6)
Шаардлагатай мөнгөн хөрөнгийн хэрэгцээ	(20.5)

Хувь нийлүүлэгчээс авсан зээл /ХНЗ+СДЭЗ+Урьдчилгаа төлбөрийн гэрээ/	11.8
Энгийн хувьцаа+ДЭХ	4.1
Гуравдагч этгээдээс авсан зээл	4.5
Нийт зээлээр болон хувьцаагаар авсан санхүүжилт	20.5

Эх сурвалж: ОТ ХХК-ийн 2010-2024 онуудын Аудитлагдсан санхүүгийн тайлан

2024 оны 12 сарын 31-ний байдлаарх зээлийн гэрээний үлдэгдэл	
Хувь нийлүүлэгчдийн зээлийн нийт	6,088
Хуримтлагдсан хүү	5,196
Хувь нийлүүлэгчдийн зээлийн нийт	11,284
Урьдчилгаа төлбөр	1,600
Хуримтлагдсан дискаунт буюу хүү	277
Урьдчилгаа төлбөрийн нийт	1,877
Төслийн санхүүжилт (ТС)	3,879
Хуримтлагдсан хүү (ТС)*	15
Спонсорын давуу эрхтэй зээл (СДЭЗ)	1,651
Хуримтлагдсан хүү (СДЭЗ)*	6
Нийт давуу эрхтэй зээл (ТС+СДЭЗ)	5,551
Эргэлтийн хөрөнгийн зээл (ЭХЗ)	70
Хуримтлагдсан хүү (ЭХЗ)*	0
Эргэлтийн хөрөнгийн зээлийн нийт	70
Зээл, хөрөнгө оруулалтын харьцаа (3:1)-д харгалзах нийт зээл	18,782
Шинэ хувьцааны санхүүжилт	-
Зээл, хөрөнгө оруулалтын харьцаа (3:1)-д харгалзах нийт өөрийн хөрөнгө	4,467
Зээл, хөрөнгө оруулалтын харьцаа (Татварын тухай хууль болон ХөрОГ-ээр зөвшөөрсөн дээд хэмжээ 3:1)	4.2
ТС-ийн 55:45 харьцаа*	31%

Эх сурвалж: ОТ ХХК-ийн сарын тайлан

**ОТ ХХК-ийн зээл ба бусад санхүүгийн өр төлбөрүүдийн нөхцөл:
2024 оны 12 сарын 31-ний байдлаарх зээлийн гэрээний үлдэгдэл:**

Санхүүжилтийн төрөл (\$ тэрбум)	Хүү болон шимтгэл, төлбөрүүд		Авсан санхүүжилтийн дүн болон шимтгэл	Эргэн төлөлт			Үлдэгдэл		
				Үндсэн	Хүү	Нийт	Үндсэн	Хүү	Нийт
Хувь Нийлүүлэгчдийн зээл	Хүүгийн хувь	(3m SOFR + Credit Adjustment spread 0.261161% + 6.5%)	10.1*	4	2.1	6.1	6.1	5.2	11.3
Төслийн санхүүжилт	Хүүгийн хувь	(6m SOFR + Credit Adjustment spread 0.42826% + 3.5%-4.61%)	4.3	0.47	1.9	2.4	3.9	0.02	3.9

Спонсорын давуу эрхтэй зээл	Шимтгэл, төлбөрүүд	Баталгааны шимтгэл (2015-2023.12.31) 1.9%-наас (2023.12.31-нээс эхлэн) 1.4%- болсон Урьдчилгаа төлбөр Амлалтын шимтгэл (хүүгийн) ОТХОБА баталгааны шимтгэл, ТС-н тогтмол шимтгэл 1.4%	0.9						
	Хүүгийн хувь	(6m SOFR + Credit Adjustment spread 0.42826% + 3.5%-4.61%)	1.7						
	Шимтгэл, төлбөрүүд	Баталгааны шимтгэл 1.4% Урьдчилгаа төлбөр 2% Амлалтын шимтгэл 37.7% (хүүгийн) ОТХОБА даатгалын шимтгэл, ТС-н тогтмол шимтгэл 1.4%	0.1	0	0.14	0.14	1.7	0.01	1.7
	Урьдчилгаа төлбөрийн гэрээ	Хорогдуулалтын хүчин зүйл	(3m LIBOR forward curve as of Apr 2022 + 6.5%)	1.6			1.6	0.28	1.9
Эргэлтийн хөрөнгийн зээл	Хүүгийн хувь	(6m SOFR + 3.0%)	0.07**						
	Шимтгэл, төлбөрүүд	Урьдчилгаа төлбөр 1.25% Амлалтын шимтгэл 40% (хүүгийн)	-				0.07	-	0.07
Нийт авсан санхүүжилт			17.8	4.5	4.1	8.6	13	6	18.8
Нийт шимтгэл, төлбөрийн дүн			1.0						

* 2015 онд \$770 саяын зээлийн хүүг үндсэн зээл рүү шилжүүлсэн

** 2024 оны 12-р сард ОТ ХХК 18 сарын хугацаатай 350 сая ам.долларын зээлийн гэрээг Эргэлтийн Хөрөнгийн Зээлийн Шуугамаар байгуулж, 12-р сарын 30-нд 70 сая ам.долларын эхний санхүүжилт авсан

Асуулт 7.

"2025 оны байдлаар Оюу Толгой төсөл нь 5,000 хүрэхгүй үндсэн ажилтантай боловч туслан гүйцэтгэгч компанийн 20,000 гаруй ажилтан уг бүтээн байгуулалтад оролцон ажиллаж байна. Тайлант онд Оюу Толгойн далд уурхайн бүтээн байгуулалт дуусаж, төсөл хэрэгжүүлэгчээс тогтвортой олборлогч компани руу шилжилт хийхтэй холбогдуулан, цаашид авч хэрэгжүүлэх шилжилтийн үеийн хүний нөөцийн бодлого, төлөвлөгөөний талаарх мэдээлэл;"

ЗОТ ХХК-ийн хариулт:

"Оюу Толгой" ХХК 2026 оноос 2032 оныг дуустал жилд Ерөнхий болон Удирдлагын дэмжлэг үзүүлэх хэлтэст 658, Дэд бүтэц ба Үйлчилгээний хэлтэст 697, Ил уурхайн үйл ажиллагааны хэлтэст 1620, Далд уурхайн үйл ажиллагааны хэлтэст 1197 хүн ажиллахаар төлөвлөж байна. "Оюу Толгой" ХХК-ийн шилжилтийн үеийн ажиллах хүчний тоог доорх хүснэгтэд харуулав.

	2022	2023	2024	2025	2026	2027	2028
Ерөнхий болон Удирдлагын дэмжлэг	625	583	583	564	555	554	553
Цахилгаан станцын төсөл	5	9	9	9	9	9	9
Дэд бүтэц & Үйлчилгээ	694	657	657	650	650	650	650
Ил уурхайн үйл ажиллагаа	1538	1423	1497	1493	1496	1491	1394
Далд уурхайн үйл ажиллагаа	1221	1785	1790	1718	1621	1614	1609
Далд уурхайн төсөл	126	262	199	35	24	24	24
Нийт ажиллах хүч	4209	4729	4735	4469	4355	4342	4239

Асуулт 8.

"Оюу Толгой ХХК-ийн борлуулалтын орлогоос Монголбанканд худалдсан валютын сүүлийн таван жил болон ирэх таван жилд төлөвлөж буй дүнгийн мэдээлэл,"

ЭОТ ХХК-ийн хариулт:

Оюу Толгой ХХК нь 2022 оны 3 дугаар сарын 24-ний өдрөөс эхлэн Монголбанкны хүсэлтээр ам.долларыг зөвхөн тус банкт арилжаалдаг байсан. 2023 оны 12 дугаар сард Оюу Толгой ХХК-ийн ам.долларын арилжааны 50%-ийг Монголбанкт, үлдсэн 50%-ийг арилжааны банкуудад нийтлэгдсэн ханшаар хуваарилах саналыг Монголбанк-аас гаргасан. Монголбанкны уг саналыг 2024 оны 3 дугаар сард Оюу Толгой ХХК нь хүлээн зөвшөөрч өнөөдрийг хүртэл дээрх саналын дагуу ам.долларыг арилжаалж байна.

2020-2024 онуудад Оюу Толгой ХХК нь нийт 6 тэрбум ам.долларыг Монголбанкт арилжаалсан байна. Ирээдүйн 5 жилд (2025-2029) гадаад валютын борлуулалтын 50 хувийг Монголбанкт үргэлжлүүлэн арилжаалах төсөөлөлтэй байгаа ба нийт 9.7 тэрбум ам.долларыг арилжаалахаар байна.

\$ тэрбум	2020	2021	2022	2023	2024	2025	2026	2027	2028	2029
Борлуулалтын орлого (цэвэр)	1.1	2.1	1.4	1.6	2.3	4.2	4.1	4.4	4.7	5.4
Санхүүжилт	1	0.5	1.6	1.7	0	0	0	0	0	0
Нийт эерэг мөнгөн урсгал	2.2	3.6	3	2.6	3.2	4.2	4.1	4.4	4.7	5.4
Дотоодод хийсэн зардал	1.4	1.8	1.6	1.9	2.1	2.5	1.8	1.8	1.8	1.8
Гадаадад хийсэн зардал	0.9	0.8	1.2	1.1	1.1	1.6	1.8	2.5	2.9	3.6
Нийт мөнгөн зарлага	2.2	2.6	2.8	2.9	3.2	4.2	3.6	4.3	4.7	5.5
Монголбанк	0.6	0.9	1.4	1.9	1.2	1.3	0.9	0.9	0.9	0.9
Арилжааны банкууд	0.7	0.9	0.2	0.8	0.1	1.3	0.9	0.9	0.9	0.9
Нийт гадаад валютын борлуулалт	1.3	1.7	1.6	1.9	2.1	2.5	1.8	1.8	1.8	1.8

Эх сурвалж "Оюу Толгой" ХХК

Асуулт 9.

"Монгол Улсын Их Хурлын 2021 оны 103 дугаар тогтоолд заасны дагуу Оюу Толгойн далд уурхайн бүтээн байгуулалтад хийгдсэн хөндлөнгийн аудитын тайлангийн мэдээлэл, хэрэв энэ аудитыг хийгээгүй бол яагаад хийгээгүй талаарх тайлбар."

ЭОТ ХХК-ийн хариулт:

2020 онд Оюу Толгой төслийн удирдлагыг хэрэгжүүлж буй Рио Тинто компани далд уурхайн төслийн шинэчилсэн хуваарь, зардлын тооцоолол (Эцсийн тооцоолол 2020)-ыг гаргасан бөгөөд энэ нь Хойд Хюго ордын 1-р давхрын геотехникийн нөхцөлийн өөрчлөлтөөс шалтгаалан ОТТЭЗҮ15-д заасан хугацаанаас 21 сараар хоцорч, бүтээн байгуулалтын зардал 1.4 тэрбум ам.доллараар нэмэгдэж байгаа тухай дурдсан. Үүнтэй холбоотой "Оюу Толгой" ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэд Монголын талын ТҮЗ-ийн гишүүдийн санаачилгаар Тусгай хороог 2020 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн 253 дугаар тогтоолоор байгуулсан.

Тусгай хорооны 2021 оны 3 дугаар сарын 15-ны өдрийн 7 дугаар хурлаар Оюу толгой төслийн зардал нэмэгдэж, гүний уурхайн ашиглалтад орох хугацаа хойшилсон асуудлаар үнэлэлт дүгнэлт гаргуулахаар Хөндлөнгийн шинжээчдийн баг (ICG)-ийг сонгон ажиллуулсан. ХШБ нь Оюу толгой төслийн 2020 оны Эцсийн Тооцоолол (DE2020)-ын мэдээлэлд үндэслэн, хуваарь хоцролт, зардал хэтрэхэд нөлөөлсөн шалтгаан болон бусад хүчин зүйлсийг Оюу Толгойн 2015 оны ТЭЗҮ-д заасан суурь

төсөв, хуваарьтай харьцуулан судалж тайлан гаргасан ба тайланг Тусгай хорооноос сонгогдсон дэлхийд хүлээн зөвшөөрөгдсөн 2 мэргэжилтнээр хянуулсан.

Уг тайланд Оюу Толгой төслийн далд уурхайн бүтээн байгуулалтын зардлын хэтрэлт нь зөвхөн геотехникийн асуудал, газрын гүний чулуулгийн нөхцөл байдлаас шалтгаалаагүй ба төслийн төлөвлөлт, менежментийн алдаа дутагдалтай байдлаас ихээхэн шалтгаалсан талаар дүгнэлт гаргасан. Мөн ИХНБУМ (ЕРСМ)-ийн үйлчилгээ болон Эзэмшигчийн Төслийн Менежментийн багийн зардал, материал дамжуулах систем, бутлуурын байгууламжуудын зардал өссөн нь зардлын хэтрэлтэд хамгийн их нөлөөлсөн ба гадаад валютын ханшийн өөрчлөлтийн ашиг нь зардлын хэтрэлтийг бууруулахад нөлөөлсөн гэж дүгнээд төслийн зардлын аудит хийлгэхийг зөвлөсөн.

Дээрх зөвлөмжийг хэрэгжүүлэх хүрээнд "Оюу Толгой" ХХК-ийн ТУЗ-ийн 2021 оны 274 дүгээр тогтоолыг 1-д "Гүний уурхайн бүтээн байгуулалтын өргөтгөлийн зардалд хөндлөнгийн аудит хийлгэх, үүний тулд уг аудитын хамрах хүрээг тодорхойлох, тайлан гаргуулж ТУЗ-д танилцуулах зорилгоор олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн, нэр хүнд бүхий хөндлөнгийн фирм ("Зардлын аудиторууд" гэх)-ийг сонгож томилохыг 2020 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн 253 тоот тогтоолоор байгуулагдсан Тусгай хороонд даалгасугай. Улмаар дүгнэлт, зөвлөмж гаргаж ТУЗ-д шуурхай танилцуулахыг тус хороонд үүрэг болгосугай." гэж, мөн тогтоолын 2-т "Дээрх 1 дүгээр зүйлд заасан зардлын аудитыг хийж гүйцэтгэхтэй холбогдон гарах нийт зардлыг Оюу Толгой ХХК хариуцах бөгөөд уг зардлыг Тусгай хорооны шаардлагатай гэж үзсэн үнийн дүнгээр батална." гэж тус тус тусгасан байдаг.

Түүнчлэн уг асуудлын талаар Монгол Улсын Их Хурлын 2021 оны "Оюу толгой ордоос Монгол Улсын хүртэх үр ашгийг нэмэгдүүлэх арга хэмжээний тухай" 103 дугаар тогтоол гарч, тогтоолын 1.3-т ОТ төслийн далд уурхайн бүтээн байгуулалтын санхүүжилтэд хөндлөнгийн аудит хийлгэх асуудал тусгагдсан.

Монгол Улсын Их Хурлын 2021 оны "Оюу толгой ордоос Монгол Улсын хүртэх үр ашгийг нэмэгдүүлэх арга хэмжээний тухай" 103 дугаар тогтоолын талаар товч дурдахад уг тогтоол нь 2 заалт, 6 дэд заалтаас бүрдэх бөгөөд тэдгээрийн 1 дэд заалт бүрэн хэрэгжсэн (Монголын талд хуримтлагдсан 2.3\$ тэрбум ам.долларын өрийг тэглэх), бусад заалт, дэд заалтуудыг хэрэгжүүлэх ажил үргэлжилж байна.

Өмнө дурдсанчлан тогтоолыг хэрэгжүүлэх "Ажлын хэсэг"-ийг Монгол Улсын Ерөнхий сайдын 2024 оны 120 дугаар захирамжаар шинэчлэн байгуулж, түүнийг Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд Ц.Туваан ахалж, Тэргүүн шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд, Шадар сайд, Хууль зүй дотоод хэргийн сайд, Сангийн сайд, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд, Эрчим хүчний сайд, бусад төрийн байгууллагын төлөөлөл бүхий 13 хүний бүрэлдэхүүнтэйгээр ажиллаж байна.

Мөн Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн хуралдааны 38 дугаар тэмдэглэл, Ерөнхий сайдын 2024 оны 120-р захирамжийн 2-т заасан үндэслэл, чиглэл, олгосон эрхийн дагуу "Ажлын хэсэг"-ийн ахлагчийн 2025 оны А/29 дүгээр тушаалаар УИХ-ын 2021 оны 103-р тогтоолын 1 дэх заалтын 2, 3, 4 дэх дэд заалтын хэрэгжилтийг хангуулах, хувь нийлүүлэгчдийн зээлийн хүүг бууруулах, шинэчлэх асуудлаар "Ажлын хэсэг"-ийг тусгайлан байгуулан ажиллуулж байна.

Монгол Улсын Их Хурлын 2021 оны "Оюу толгой ордоос Монгол Улсын хүртэх үр ашгийг нэмэгдүүлэх арга хэмжээний тухай" 103 дугаар тогтоолын 1.3 дахь дэд заалтад "Оюу толгойн далд уурхайн бүтээн байгуулалтын санхүүжилтэд хөндлөнгийн аудит хийлгэх;" гэж тусгагдсан.

Тогтоолын энэ заалтын хэрэгжилттэй холбогдуулан Рио Тинто компани "Ernst & Young" компаниар далд уурхайн бүтээн байгуулалтын санхүүжилтэд хөндлөнгийн аудит хийлгэж, холбогдох мэдээлэл (тайланг хавсаргав)-ийг Ажлын хэсэгт хүргэсэн бөгөөд үүнтэй "Эрдэнэс Оюу Толгой" ХХК-ийн хувьд байр суурь нэгдээгүй.

Оюу толгойн далд уурхайн бүтээн байгуулалтын санхүүжилтэд хөндлөнгийн аудит хийлгэх асуудал УИХ-ын тогтоолд тусгагдсан бол харин түүний зардалд

хөндлөнгийн аудит хийлгэх асуудал ОТ ХХК-ийн ТУЗ-ийн 2021 оны 274 дүгээр тогтоолд тусгагдсан тул санхүүжилт болон зардалд зэрэгцсэн аудит хийлгэх, ингэхдээ "Эрдэнэс Оюу Толгой" ХХК-ийн оролцоог хангах санал, шаардлагыг удаа дараа илэрхийлж, үүний үр дүнд талууд нэгдсэн ойлголтод хүрч, ажлын цар хүрээг боловсруулахаар харилцан тохиролцоод байна.

Улмаар тогтоолын энэ заалтын болон Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн хуралдааны 38 дугаар тэмдэглэлийн хэрэгжилтийг хангуулах зорилгоор Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайдын 2025 оны А/29 дүгээр тушаалаар байгуулагдсан "Ажлын хэсэг"-ээс баталсан төлөвлөгөөний дагуу ОТ-н далд уурхайн бүтээн байгуулалтын санхүүжилт болон зардалд хөндлөнгийн аудит хийлгэх ажлын хүрээнд зөвлөх үйлчилгээний ажлын даалгаврын төслийг эцэслэн боловсруулж, Рио Тинто компани руу хүргүүлэхээр ажиллаж байна.

Санхүүжилтийн болон зардлын аудитыг 2025 онд гүйцэтгэж дуусгах төлөвлөгөөтэй ажиллаж байна.

Асуулт 10.

"Рио Тинто компани нь олон улсын хөрөнгийн биржүүдэд нээлттэй арилжаалагддаг Туркойз Хилл Ресурсес компанийн гаргасан хувьцааны 49% хувийг 2022 онд худалдан авч, хаалттай компани болгосны улмаас өмнө нь олон нийтэд нээлттэй байсан Оюу Толгой төслийн талаарх мэдээлэл хаалттай болсон. Байгалийн баялгийн үр өгөөж, үр ашгийг иргэдэд хүртээх, сайн засаглалыг хэрэгжүүлэх, мэдээллийн ил тод, нээлттэй, тэнцвэртэй байдлыг хангах зорилтын хүрээнд Ашигт малтмалын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.6-д заасны дагуу Оюу Толгой ХХК-ийг нээлттэй компани болгохоор төлөвлөж байгаа эсэх, хувьцааг Монголын хөрөнгийн бирж дээр олон нийтэд санал болгох бэлтгэл ажил хийгдэж байгаа эсэх талаарх мэдээлэл."

ЭОТ ХХК-ийн хариулт

Ашигт малтмалын тухай /2006 оны шинэчилсэн найруулга/ хууль 2006 оны 7 дугаар сарын 08-ны өдөр батлагдаж, түүнийг мөн оны 8 дугаар сарын 26-ны өдрөөс эхлэн дагаж мөрджээ.

Тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.6 дахь хэсэгт дурдагдсан **"Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшиж байгаа этгээд нь хувьцааныхаа 10-аас доошгүй хувийг Монголын хөрөнгийн биржээр арилжина."** гэх зохицуулалт нь Ашигт малтмалын тухай хуулийн шинэчилсэн найруулгыг батлах үед тусгагдсан байсан, түүнээс хойш уг хэсэгт нэмэлт, өөрчлөлт ороогүй.

Нөгөөтээгүүр, УИХ-ын 2008 оны 40 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралтаар "Стратегийн ач холбогдол бүхий ... Оюу толгойн зэс-алтны ордыг хамтарч ашиглах хөрөнгө оруулалтын гэрээ байгуулах үндсэн зарчим, удирдамж"-ийг баталсан бөгөөд түүнд гадаадын хөрөнгө оруулагч талтай байгуулах гэрээг **"хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хууль тогтоомжуудад нийцүүлэн хийх"**-ийг тусгасан.

Гэтэл бодит байдал дээр Ашигт малтмалын тухай хуулийн 5.6 дахь хэсэг болон УИХ-ын 2008 оны 40 дүгээр тогтоолын шаардлага Оюу Толгой төслийн "Хөрөнгө оруулалтын гэрээ", "Хувь нийлүүлэгчдийн гэрээ"-нд "дутуу, хэлбэр төдий, зөрчилтэй" байдлаар тусгагдсан. Өөрөөр хэлбэл, дээрх хууль, УИХ-ын тогтоолын хэрэгжилт Оюу толгой төсөлд хангагдаагүй. Тайлбарлавал,

Оюу Толгой төслийн,

- "Хөрөнгө оруулалтын гэрээ"-ний 1.9-д "Ашигт малтмалын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.6-д заасан үүрэг нь Хувь нийлүүлэгчдийн гэрээний 15.3(в) заалтын дагуу биелэгдэх бөгөөд Төрийн өмчит компани Хувь

нийлүүлэгчдийн гэрээний 15.3(в) заалтад тусгасан шаардлагуудыг биелүүлж чадахгүй болсон аливаа тохиолдолд **Засгийн газар уг үүргийг өөртөө хүлээн авч хариуцна.**" /15.3(в) заалтын дугаарлалт 2011 онд 16.3(в) болж өөрчлөгдсөн/;

- "Хувь нийлүүлэгчдийн гэрээ" (нэмэлт, өөрчлөлт оруулж дахин тодотгосон)-ний 16.3(в)-д "Хөрөнгө оруулалтын гэрээний 1.9-д заасны дагуу Ашигт малтмалын тухай хуулийн 5.6-д заасан шаардлагыг хангах үүднээс **Засгийн газарт шилжүүлсэн хувьцааны 10 (арав)-аас доошгүй хувийг Монгол Улсын Хөрөнгийн бирж дээр худалдах асуудлыг ТӨК хариуцах бөгөөд ийнхүү шилжүүлэх нь энэхүү Гэрээний 16-д заасан шилжүүлгийн хязгаарлалтуудад хамаарахгүй. Хөрөнгө оруулалтын гэрээний 1.9-д заасныг хязгаарлахгүйгээр Айвенхоугийн Хувь нийлүүлэгчид болон Компани нь энэхүү Гэрээний 16.3(в)-д заасны дагуу ТӨК-ийн хэрэгжүүлэх үүргийг гүйцэтгүүлэхийг шаардахгүй.**" гэж тусгагдсан.

Дээрхээс үзвэл, Ашигт малтмалын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.6 дахь хэсэгт зааснаар "Оюу Толгой" ХХК нь хувьцааныхаа 10-аас доошгүй хувийг Монголын хөрөнгийн биржээр арилжаалах хуулийн шаардлагыг хангуулах ёстой боловч үнэн хэрэгтээ түүний Монголын талын хувьцаа эзэмшигч "Эрдэнэс Оюу Толгой" ХХК-ийн эзэмшиж буй 34% хувийн хувьцааны 10% хувиас доошгүй (ОТ ХХК-ийн хувьцааны 3.4% буюу хуулийн шаардлагаас 3 дахин бага)-г хөрөнгийн биржээр арилжаалах талаар тохиролцож, "гэрээлсэн" байдаг.

Цаашид "Хөрөнгө оруулалтын гэрээ" болон "Хувь нийлүүлэгчдийн гэрээ"-н дэх "хуулийн зөрчилтэй" дээрх асуудлыг Монгол Улсын Их Хурлын 2019 оны "Оюу толгой ордын ашиглалтад Монгол Улсын эрх ашгийг хангуулах тухай" 92 дугаар тогтоолын 1.1 дэх заалтад: *"Монгол Улсын Засгийн газар болон Айвенхоу майнз Монголиа Инк ХХК, Айвенхоу майнз Лтд, Рио Тинто Интернэшнл Холдингс Лтд компани хооронд 2009 оны 10 дугаар сарын 06-ны өдөр байгуулсан Хөрөнгө оруулалтын гэрээ, Эрдэнэс Монгол ХХК болон Айвенхоу Оюу Толгой (Би Ви Ай) Лтд, Оюу Толгой Нидерланд Би Ви, Оюу Толгой ХХК хооронд 2011 оны 06 дугаар сарын 08-ны өдөр байгуулсан Хувь нийлүүлэгчдийн гэрээ (нэмэлт, өөрчлөлт оруулж дахин тодотгосон)-ний хэрэгжилтийг Улсын Их Хурлын 2008 оны "Үндсэн зарчим, удирдамж батлах тухай" 40 дүгээр тогтоол, 2009 оны "Оюу толгой ордыг ашиглах хөрөнгө оруулалтын гэрээний тухай" 57 дугаар тогтоол болон Монгол Улсын хууль тогтоомжтой уялдуулан сайжруулах чиглэлээр цогц арга хэмжээ авах," гэсний дагуу өөрчилж, төсөлд Монгол Улсын хууль тогтоомжийн шаардлага, хэрэгжилтийг хангуулах нь зүйтэй юм.*

"Эрдэнэс Оюу Толгой" ХХК нь "Хөрөнгө оруулалтын гэрээ", "Хувь нийлүүлэгчдийн гэрээ"-ний хэрэгжилтийн талаар, тэдгээрт Монгол Улсын хууль тогтоомжийн шаардлагыг хангуулах, боловсронгуй болгох, өөрчлөх талаарх саналаа Монгол Улсын Ерөнхий сайдын захирамжаар байгуулагдсан, гадаадын хөрөнгө оруулагч талтай яриа хэлэлцээр хийх чиг үүрэг бүхий "Ажлын хэсэг"-т танилцуулж, хүргүүлж байсныг эцэст нь дурдъя.

"Эрдэнэс Оюу Толгой" ХХК
2025 оны 4 дүгээр сарын 29-ний өдөр.

--- оОо ---

Rio Tinto

Rio Tinto
6 St James's Square
London SW1Y 4AD
United Kingdom
Tel: +44 20 7781 2000

Private & confidential
MP Tuvaan Tsevegdoj
Minister of Industry and Mineral Resources and
Chair of the Government Working Group
Government Building II
United Nations Street 5/2
Ulaanbaatar 15160
Mongolia

19 December 2024

Dear Minister Ts.Tuvaan,

Thank you for your letter dated 12 December 2024 informing us of the formation of a new Government Working Group and expressing the Government's desire to resolve the ongoing tax dispute with Oyu Tolgoi LLC ("OT") and proposing the commencement of negotiations.

We share the Government of Mongolia's ("Government") commitment to resolve the ongoing tax dispute through mutual understanding and come to a clear and comprehensive agreement to avoid any future tax disputes.

With the signing of the Investment Agreement ("IA") between OT and the Government in 2009, OT has embarked on a path to become a major global copper producer. However, disputed matters are still pending at international arbitration (LCIA Arbitration Case No. 204623) ("Tax Arbitration") and the Mongolian Administrative Court and Tax Dispute Resolution Council. To strengthen our long-term partnership and further maximize the benefits of the joint asset, on behalf of OT, we are prepared to make the following major concessions to resolve the abovementioned disputed matters on a without prejudice basis, reserving all legal rights and the position of OT in the existing Tax Arbitration, courts and under the IA:

1. OT is willing to waive the right to claim the disputed amount of principal taxes of MNT 840 billion assessed by Tax Assessment Acts covering the 2013-2020 years. However, given we believe that OT has paid all taxes in accordance with relevant agreements and laws, it is difficult for us to accept the interest and penalties in the amount of MNT 445 billion imposed under the tax assessment acts.
2. To operate without any tax disputes in the future and to achieve a mutual understanding of principles for tax treatments, we accept the position of the General Taxation Department ("GDT") on the following matters:
 - 2.1 apply the Central Customs Laboratory's result as the primary basis for determining the content of metals subject to royalty (provided that any disagreement as to the accuracy of an assay would be confirmed by a jointly appointed internationally accredited laboratory);
 - 2.2 apply the international market price for copper, gold and silver announced by the Government and the Bank of Mongolia respectively (provided that any discrepancies in price to be resolved within an agreed legal framework);
 - 2.3 pay the disputed immovable property tax at the applicable rate;
 - 2.4 pay the disputed personal income tax at the applicable rate;
 - 2.5 accept some expenses, such as those incurred in connection with employees' training, to be reported as non-deductible corporate income tax ("CIT") expenses;

2.6 the postponement of the depreciation of the assets used in the development of the underground mine until the date of the commencement of the underground sustainable production on 13 March 2023, and

2.7 to change the depreciation period of the disputed assets from 10 years to 40 years.

3. Within the framework of clauses 2.8 and 2.9 of the IA, in accordance with Mongolia's double taxation treaties established with 26 countries, withholding tax should be imposed on loan interest payments at the rate of the relevant double taxation treaty; and furthermore no withholding tax on management services payment and payments for offshore services paid by OT;
4. Under clause 18(c) of the Amended and Restated Shareholders' Agreement ("ARSHA") of OT dated 8 June 2011, it has been agreed that Erdenes Oyu Tolgoi LLC is liable for 34% of the withholding tax ("WHT") applicable to OT's shareholder loan interest. However, given this matter remains in dispute, we seek to have it resolved;
5. Not to pay royalties on non-revenue-generating impurity elements that are not economical from a technical perspective (i.e. elements contained in concentrate other than copper, gold and silver) as per clauses 3.12 and 3.13 of the IA;
6. Further to clauses 2.25 and 2.27 of the IA, strategic and operational management service payments, guarantee fees and shareholder loan interest payments are fully CIT-deductible expenses. Therefore, the tax loss reported in the years 2016-2020 will be adjusted by the GDT with the amount of these payments;
7. Under clause 2.26 of the IA, GDT to confirm the amount of loss carried forward of OT for the years 2013-2020 and that OT is entitled to calculate its losses carried forward in US dollars, which is the primary accounting currency, and
8. GDT to confirm investment tax credits for OT for 2013-Q1 2017 in US dollars as per clauses 2.26 and 2.33 of the IA.

If the Government accepts this renewed package offer, the following sequenced actions need to be undertaken: (i) the detailed terms being agreed and documented in a legally binding settlement agreement signed by OT and the Government (competent authorities); (ii) both parties withdrawing their claims within the Tax Arbitration on the basis that those claims are resolved immutably; (iii) the parties jointly providing the settlement agreement to the Arbitral Tribunal in the Tax Arbitration for confirmation in the form of an arbitral award, and that award being issued by the Tribunal; and (iv) the termination of the arbitration.

Provided the settlement agreement is agreed and signed, OT would be willing to withdraw its claim and complaint at the Mongolian Administrative Court and Tax Dispute Resolution Council respectively.

We are available for a meeting on 23 December, as requested, and are looking forward to presenting our proposed solution and discussing it with you further. We will provide the names of our attendees in advance.

We look forward to continuing to work together for the future success of Oyu Tolgoi for all stakeholders.

Yours faithfully,



Katie Jackson
Chief Executive, Copper

Cc: Deirdre Lingenfelder, Chief Executive Officer, Oyu Tolgoi LLC

АЖ ҮЙЛДВЭР, ЭРДЭС БАЯЛГИЙН САЙД,
ЗАСГИЙН ГАЗРЫН АЖЛЫН ХЭСГИЙН АХЛАГЧ Ц.ТУВААН ТАНАА

2024 оны 12 дугаар сарын 19-ний өдөр

Монгол Улсын Засгийн газрын Ажлын хэсэг шинээр байгуулагдсан тухай болон татварын маргааныг "Оюу Толгой" ХХК-тай /цаашид "ОТ ХХК" гэх/ шийдвэрлэхийг Засгийн газраас эрмэлзэж байгаагаа илэрхийлэн, хэлэлцээ эхлүүлэхийг санал болгосон 2024 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн албан тоотыг ирүүлсэнд Танд талархал илэрхийлье.

Дээрх татварын маргааныг харилцан ойлголцлын замаар шийдвэрлэж, цаашид татварын аливаа маргаануудаас зайлсхийхийн тулд нэг мөр ойлголт, иж бүрэн тохиролцоонд хүрэх Засгийн газрын эрмэлзлийг бид талархан хүлээн авч байна.

ОТ ХХК болон Засгийн газрын хооронд 2009 онд Хөрөнгө оруулалтын гэрээ /цаашид "ХөОГ" гэх/ байгуулагдсанаар Оюу Толгой дэлхийн томоохон зэсийн үйлдвэрлэгч болох хөгжил дэвшлийн замдаа нэгэнт гарсан билээ. Гэсэн хэдий ч маргаантай асуудлууд өнөөг хүртэл олон улсын арбитр ("Лондоны Олон улсын арбитрын шүүх"-ийн арбитрын ажиллагаа №: 204623) /цаашид "Татварын арбитр" гэх/ болон Монгол Улсын Захиргааны хэргийн шүүх, Татварын маргаан таслах зөвлөл дээр шийдлээ хүлээсээр байна. Иймд урт хугацааны түншлэлээ бэхжүүлж, хамтарсан төслийн үр өгөөжийг улам бүр нэмэгдүүлэхийн тулд ОТ ХХК-ийн нэрийн өмнөөс дээрх маргааныг эв зүйгээр шийдвэрлэж, цаашид татварын аливаа маргаангүй байх үүднээс ХөОГ болон ОТ ХХК-ийн арбитр, шүүхийн үйл ажиллагаанд хамаарах хууль ёсны эрх, байр суурийг хөндөхгүйгээр дараах томоохон буултыг хийхэд бэлэн байна. Үүнд:

1. ОТ ХХК нь 2013-2020 оныг хамарсан Татварын нөхөн ногдуулалтын актуудаар ногдуулсан маргаантай байгаа 840 тэрбум төгрөгийн нөхөн татварын дүнг нэхэмжлэх эрхээсээ татгалзаж буулт хийхэд бэлэн байна. Гэхдээ ОТ ХХК нь холбогдох гэрээ болон хууль тогтоомжийн дагуу төлбөл зохих бүхий л татвараа төлсөн гэж үзэж байгаа тул тогтоосон торгууль, алдангийн дүн болох 445 тэрбум төгрөгийг хүлээн зөвшөөрөхөд нэн хүндрэлтэй байна.
2. Ирээдүйд татварын маргаангүй үйл ажиллагаа явуулах, татвар ногдуулах зарчмын хувьд нэгдсэн ойлголтод хүрэхийн тулд дараах асуудлуудад Татварын ерөнхий газар /цаашид "ТЕГ" гэх/-ын байр суурийг хүлээн зөвшөөрч байна. Үүнд:
 - 2.1 Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр ногдуулах металлын агуулгыг тодорхойлохдоо Гаалийн төв лабораторийн дүгнэлтийг анхдагч болгон ашиглах (лабораторийн дүгнэлтийн талаар маргаан гарсан тохиолдолд талуудын хамтран томилсон олон улсын итгэмжлэгдсэн лабораториор үнэн зөвийг баталгаажуулах);
 - 2.2 Монгол Улсын Засгийн газар болон Монголбанкнаас зарласан зэс, алт, мөнгөний олон улсын зах зээлийн үнийг баримтлах (ингэхдээ аливаа зөрүү гарсан тохиолдолд харилцан тохиролцсон эрх зүйн хэм хэмжээний хүрээнд шийдвэрлэх);
 - 2.3 Маргаан бүхий үл хөдлөх эд хөрөнгийн албан татварыг холбогдох хувь хэмжээгээр төлөх;
 - 2.4 Маргаан бүхий хувь хүний орлогын албан татварыг холбогдох хувь хэмжээгээр төлөх;
 - 2.5 Ажилчдын сургалттай холбоотой гарсан гэх мэт тодорхой зардлуудыг ААНОАТ-ын хасагдахгүй зардлаар тайлагнахыг хүлээн зөвшөөрөх;
 - 2.6 Гүний уурхайн бүтээн байгуулалтад ашигласан хөрөнгийн элэгдэл тооцох хугацааг Гүний уурхайн олборлолт эхэлсэн өдөр болох 2023 оны 3 дугаар сарын 13-ны өдөр хүртэл хойшлуулсныг хүлээн зөвшөөрөх;
 - 2.6 Маргаан бүхий хөрөнгийн элэгдлийн хугацааг 10 жил байсныг 40 жил болгон өөрчлөх.

Албан бус орчуулга

3. ХөОГ-ний 2.8 болон 2.9-н хүрээнд Монгол Улсын 26 улстай байгуулсан давхар татварын гэрээний дагуу эзэлийн хүүгийн төлбөрт холбогдох давхар татварын гэрээний хувь хэмжээгээр тооцож суутган татвар ногдуулах, мөн түүнчлэн ОТ ХХК-ийн төлөх менежментийн үйлчилгээний төлбөр болон Монгол Улсын нутаг дэвсгэрээс гадна гүйцэтгэсэн ажил, үйлчилгээний төлбөрт суутган татвар ногдуулахгүй байх;
4. 2011 оны 6 дугаар сарын 8-ны өдрийн Нэмэлт, өөрчлөлт оруулж, дахин тодотгосон Хувь нийлүүлэгчдийн гэрээний 18(в) заалтын дагуу Эрдэнэс Оюу Толгой ХХК нь ОТ ХХК-ийн хувь нийлүүлэгчдийн эзэлийн хүүд ногдох суутган татварын 34 хувийг хариуцахаар байгаа боловч энэ асуудал маргаан дагуулсан хэвээр байгаа тул Эрдэнэс Оюу Толгой ХХК хариуцах эсэхийг харилцан тохиролцож шийдвэрлэх хүсэлтэй байна;
5. Технологийн хувьд салгаж авах боломжгүй, эдийн засгийн үр ашиггүй, орлого олдоггүй дагалдах элементүүдэд (өөрөөр хэлбэл баяжмалд агуулагдсан зэс, алт, мөнгөнөөс бусад элементүүд) ХөОГ-ний 3.12, 3.13-т тус тус заасны дагуу ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр ногдуулахгүй байх;
6. ХөОГ-ний 2.25, 2.27-д тус тус заасны дагуу стратегийн болон үйл ажиллагааны менежментийн үйлчилгээний төлбөр, хувь нийлүүлэгчдийн эзэлийн хүүгийн болон баталгааны төлбөрүүдийг ААНОАТ-ын хасагдах зардлаар тооцохоор байгаа билээ. Иймд 2016-2020 онд тайлангаар гарсан татварын алдагдлыг эдгээр төлбөрүүдийн дүнгээр ТЕГ-аас залруулах;
7. ХөОГ-ний 2.26-д заасны дагуу 2013-2020 онд ААНОАТ-н тайлангаар гарсан алдагдал болон түүнийг тайлагналын валют буюу ам.доллараар тооцохыг ТЕГ-аас баталгаажуулах;
8. ОТ ХХК-ийн 2013-2017 оны 1 дүгээр улирал дуустал тайлагнасан хөрөнгө оруулалтын татварын хөнгөлөлтийг ХөОГ-ний 2.26, 2.33-т тус тус заасны дагуу ам.доллараар ТЕГ-аас баталгаажуулах.

Засгийн газрын зүгээс бидний энэхүү шинэчилсэн багц саналыг хүлээн авсан тохиолдолд дараах шаталсан арга хэмжээнүүдийг хамтран хэрэгжүүлэх хэрэгтэй билээ: Үүнд (i) ОТ ХХК болон Засгийн газар (эрх бүхий байгууллага)-ын харилцан тохиролцсон нарийвчилсан зохицуулалтыг эвлэрлийн гэрээгээр албажуулах; (ii) тухайн асуудлыг нэг мөр шийдвэрлэгдсэн гэж үзэн талууд Татварын арбитраг гаргасан тус тусын нэхэмжлэлээсээ татгалзах; (iii) талууд эвлэрлийн гэрээг Татварын арбитраг шүүхэд хамтран хүргүүлж эцсийн шийдвэр гарган баталгаажуулах; (iv) арбитраг ажиллагааг дуусгавар болгох.

Эвлэрлийн гэрээг харилцан тохиролцож, гарын үсэг зурснаар ОТ ХХК нь Монгол Улсын Захиргааны хэргийн шүүх, Татварын маргаан таслах зөвлөлд гаргасан нэхэмжлэл, гомдлоосоо татгалзах болно.

Та бүхнээс ирүүлсэн албан бичигт дурдсанчлан бид 12-р сарын 23-ны өдөр уулзаж өөрсдийн санал болгож буй шийдлээ танилцуулж, харилцан санал солилцоход бэлэн байна. Уулзалтад оролцох ажилтнуудынхаа нэрсийг урьдчилан хүргүүлэх болно.

Оюу Толгойн ирээдүйн амжилтын төлөө бүх оролцогч талуудад өгөөжтэй байхаар бид үргэлжлүүлэн хамтран ажиллахдаа таатай байх болно.

Гүнээ хүндэтгэсэн,

Кэйти Жаксон

Гүйцэтгэх захирал, Рио Тинто Зэсийн групп

Хувийг: "Оюу Толгой" ХХК-ийн Гүйцэтгэх захирал Дэйдрэ Лингенфэлдерт



29 March 2023

Honourable Minister Kh. Nyambaatar
Minister of Justice and Internal Affairs
Chair of the Government Working Group on Oyu Tolgoi
Government of Mongolia
Ulaanbaatar, Mongolia

Dear Minister Kh. Nyambaatar,

Re: Independent audit of Oyu Tolgoi project financing

On behalf of Rio Tinto, I would like to express our appreciation for the ongoing engagement between representatives of different levels of Government and the Oyu Tolgoi (OT) shareholders over recent months and acknowledge the significant progress made towards the implementation of Parliament Resolution #103, and furthermore would like to re-iterate Rio Tinto's ongoing commitment to fully implementing this Resolution.

This correspondence is to provide you with an update on the status of the independent audit of the Oyu Tolgoi project financing mechanism, as requested in item 1(3) of Resolution 103.

Item 1(3): Conduct an independent audit in relation to Oyu Tolgoi underground development financing.

I refer you to the attached Letter of Representation and Opinion Letter, provided by audit firm Ernst & Young, which the International Investors commissioned to provide a comprehensive review and opinion in relation to the use of the project finance funds for the OT project, namely ensuring that all payments amounting to the sum of USD4,274,320,585.41 have been re-injected into OT in the form of shareholder debt and equity.

The findings of the referenced letters from the independent auditor confirm that funds amounting to USD4,274,320,585.41 were provided by Project Finance Lenders to Turquoise Hill Resources (TRQ) through OT and provides assurance that TRQ in turn issued USD4,274,320,585.41 in funding to OT through shareholder loans and equity.


This confirms that all of the Project Finance funds were ultimately used in support of the OT development and were not used for any other purposes. As we have communicated previously, the PF funds were initially drawn in full by TRQ in order to repay shareholder loans which were owed by OT at a higher interest rate. The amounts were then re-invested into OT as they were needed, reducing costs for OT LLC. We trust that this provides clarity on this issue which will be to the satisfaction of all interested parties. As a major

international audit firm, EY's independence and capability can be assured and I hope that this provides further reassurance about this matter.

We believe that the undertaking of this audit and provision of the attached letters satisfies the requirement of item 1(3) of Resolution 103 to conduct an independent audit in relation to OT underground development financing, and hope that the Ministry of Justice and Internal Affairs are satisfied with the conclusion.

In closing, I would like to reiterate our appreciation of our close collaboration as we reach sustainable production in the first half of 2023 and increasing the value that OT delivers to all shareholders.

Yours Sincerely,



Munkhsukh Sukhbaatar
Managing Director Growth and Development, Rio Tinto Copper

ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН ЯАМНЫ САЙД,
ЗАСГИЙН ГАЗРЫН АЖЛЫН ХЭСГИЙН АХЛАГЧ
Х.НЯМБААТАР ТАНАА

**Оюу Толгой төслийн санхүүжилтийн талаарх хөндлөнгийн аудитын
дүгнэлтийн тухай**

"Рио Тинто" компанийн нэрийн өмнөөс миний бие Монгол Улсын Засгийн газрын шат бүр дэх албан хаагчид болон Оюу Толгойн /ОТ/ хувьцаа эзэмшигчдийн хооронд сүүлийн саруудад тасралтгүй үргэлжилж буй хамтын ажиллагаанд талархлаа илэрхийлж, УИХ-ын 103 дугаар тогтоолыг хэрэгжүүлэхэд томоохон ахиц гарсныг энд тэмдэглэхийг хүсэж байна. Түүнчлэн "Рио Тинто" компанийн зүгээс дээрх тогтоолыг бүрэн хэрэгжүүлэхээр ажиллаж байгаагаа дахин нотолж байна.

Энэхүү албан тоотоор 103 дугаар тогтоолын 1(3)-т "Оюу Толгойн далд уурхайн бүтээн байгуулалтын санхүүжилтэд хөндлөнгийн аудит хийлгэх" гэж үүрэг болгосон ОТ төслийн санхүүжилтийн механизмын хөндлөнгийн аудитын талаарх мэдээллийг Танд хүргүүлж байна.

Олон улсын хөрөнгө оруулагчдын хүсэлтээр ОТ-д зарцуулсан төслийн санхүүжилтийн хөрөнгийн зарцуулалтын иж бүрэн тайлан болон дүгнэлтийг гаргасан "Эрнст энд Янг" фирмын Төлөөлөх албан тоот, Дүгнэлт хоёрыг Танд хүргүүлж байна. Энэхүү дүгнэлт нь 4,274,320,585.41 ам.доллартай тэнцэх нийт дүнтэй төлбөрийг хувьцаа эзэмшигчийн өр болон өөрийн хөрөнгө хэлбэрээр ОТ-д буцаан оруулсныг тухайлан авч үзсэн билээ.

Хавсаргасан захидал дахь хөндлөнгийн аудиторын дүгнэлтүүд нь Төслийн санхүүжилтийн зээлдүүлэгчдээс "Туркойз Хилл Ресурсэс" /ТХР/ компанид ОТ-оор дамжуулан 4,274,320,585.41 ам.доллартай тэнцэх хэмжээний санхүүжилт олгосон болохыг нотолж байгаа бөгөөд ТХР нь эргүүлээд хувьцаа эзэмшигчдэд хувьцаа эзэмшигчдийн зээл болон өөрийн хөрөнгө хэлбэрээр 4,274,320,585.41 ам.долларын санхүүжилт олгосон гэдэгт баталгаа өгч байна.

Үүгээр Төслийн санхүүжилтийн бүх хөрөнгийг эцсийн дүндээ ОТ-н бүтээн байгуулалтыг дэмжихэд зарцуулсан бөгөөд ямар нэг өөр зориулалтаар ашиглаагүй болох нь батлагдаж байна. Өмнө нь бидний зүгээс мэдэгдэж байсанчлан, ОТ-н төлөх ёстой хувьцаа эзэмшигчийн өндөр хүүтэй зээлийг төлөхийн тулд Төслийн санхүүжилтийн хөрөнгийг ТХР-ын талаас эхэндээ бүрэн хэмжээгээр татжээ. Дараа нь ОТ ХХК-ийн зардлыг бууруулж, шаардлагатай хэмжээгээр ОТ-д дахин хөрөнгө оруулсан байна. Энэхүү тайлбар нь бүх сонирхогч талуудын сэтгэлд нийцэж уг асуудлыг тодорхой болгосон гэдэгт итгэлтэй байна. Олон улсын томоохон аудитын

Албан бус орчуулга

фирм болох "Эрнст энд Янг"-ын хараат бус байдал, чадавхад итгэж болох бөгөөд дээрх тайлбарт нэмэлт баталгаа болж чадна гэж найдаж байна.

Энэхүү аудитыг хийлгүүлж, хавсаргасан албан бичгүүдийг хүргүүлснээр ОТ-н далд уурхайн бүтээн байгуулалтын санхүүжилттэй холбоотой хөндлөнгийн аудит хийх тухай 103 дугаар тогтоолын 1(3) дахь хэсэгт заасан шаардлагыг биелүүлж дууслаа гэж бидний зүгээс үзэж байна. Хууль зүй, дотоод хэргийн яам энэхүү дүгнэлттэй санал нийлж байгаа гэж итгэж байна.

Төгсгөлд нь бид 2023 оны эхний хагаст тогтвортой үйлдвэрлэлд хүрч, ОТ-оос бүх хувьцаа эзэмшигчдэд хүргэх үнэ цэнээ нэмэгдүүлж байгаа бидний нягт хамтын ажиллагаанд талархаж байгаагаа дахин илэрхийлье.

Хүндэтгэсэн,

Сүхбаатарын Мөнхсүх
Рио Тинтогийн Зэсийн группийн
Өсөлт, хөгжил хариуцсан Захирал



**Building a better
working world**

Ernst & Young
11 Mounts Bay Road
Perth WA 6000 Australia
GPO Box M338 Perth WA 6840

Tel: +61 8 9429 2222
Fax: +61 8 9429 2436
ey.com.au

The Directors
Rio Tinto Services Limited
Level 33, 120 Collins Street
Melbourne 3000
Victoria

7 March 2023

Private and confidential

Oyu Tolgoi Turquoise Hill Equity Loan Assurance Opinion

Dear Directors

The purpose of this letter is to communicate matters that we are required to communicate to you in writing by professional standards or that in our judgement as auditors warrant written communication.

In accordance with our Supply Order dated 25 November 2021, the purpose of our engagement was to provide an assurance opinion in relation Re-Advance payments receipted by Oyu Tolgoi LLC from Oyu Tolgoi Netherlands BV (a controlled subsidiary of Turquoise Hill Resources Limited) amounting to USD4,274,320,585.41 between 13 October 2016 and 11 June 2020 in the form of shareholder debt and equity payments as presented in the Re-Advance Notice dated 25 May 2020.

Based on our procedures performed, and as outlined below, we verified the receipt of USD 4,274,320,585.41 from Oyu Tolgoi Netherlands BV to Oyu Tolgoi LLC between 13 October 2016 and 11 June 2020 in the form of shareholder debt or equity in accordance with the Grid Loan 2 agreement.

Our testing procedures are substantially complete and upon resolution of the following outstanding issues, we anticipate issuing an unqualified assurance opinion:

- ▶ Subsequent events review to the date of signing the assurance opinion
- ▶ Receipt of the signed management representation letters.

Significant area of attention

The below relates to a significant area of assurance attention, critical in understanding the Oyu Tolgoi LLC funding arrangement:

(a) Oyu Tolgoi LLC funding structure

Oyu Tolgoi LLC is a Mongolian joint venture entity, with joint venture participants Erdenes Oyu Tolgoi (34% ownership and an entity owned by the Government of Mongolia) and Oyu Tolgoi Netherlands BV (66% ownership and an entity owned by Turquoise Hill Resources Limited). As at the time the funding was provided, Rio Tinto had a 50.8% interest in Turquoise Hill Resources Limited and is the joint venture operator. Refer to Appendix 1 for the detailed ownership structure.



Building a better
working world

2

The funding of the Oyu Tolgoi LLC mine site development was through both equity contributions from the joint venture participants and through a separate shareholder loan agreement with Turquoise Hill Resources Limited (the Amended and Restated Shareholders Agreement dated 8 June 2011).

The terms and conditions of the Amended and Restated Shareholder Agreement dated 8 June 2011 outlines that when funds are requested through 'Called Sum Notices', Joint Venture participants are to pay the called sum in accordance with their percentage interest. The Amended and Restated Shareholder Agreement also outlines that Erdenes Oyu Tolgoi LLC has the option to contribute either whole or part of the called sum amount. Where Erdenes Oyu Tolgoi LLC elects not to make any contribution to the called sum, Oyu Tolgoi Netherlands BV will contribute for the part not paid on behalf of Erdenes Oyu Tolgoi LLC. We note in all Called Sum Notices, Erdenes Oyu Tolgoi LLC elected to not contribute.

Subsequent to the issue of the Called Sum Notice and the Erdenes Oyu Tolgoi LLC contribution election, in accordance with Grid Loan 2 Oyu Tolgoi LLC can request for a Re-Advance amount (issued in a Re-Advance Notice) which can be treated as either debt or equity.

Per clause 3.3 (a) of the Grid Loan 2 agreement, the Re-Advance is a redraw of the balance Oyu Tolgoi LLC repaid to Oyu Tolgoi Netherlands BV under their previous shareholder loan agreements (Grid Loan 1 and Exiting Shareholder loan). The maximum amount of funds to be 'Re-Advanced' back to Oyu Tolgoi LLC would be limited to the total amount repaid. The total amount repaid equated to USD 4,274,320,117.98.

As at 31 December 2015, Oyu Tolgoi LLC's total outstanding shareholder loan balance to Turquoise Hill Resources and its subsidiaries (including principal and accrued interest) amounted to USD 6.87 billion. In the same year, Oyu Tolgoi LLC executed a USD 4.4 billion Project Finance agreement with banks and financial institutions to fund the construction of the Hugo North Lift 1 section of the underground mine.

As at 31 December 2016, Oyu Tolgoi LLC had drawn down on the Project Finance facility by USD 4.3 billion of which USD 4.2 billion was used to partially repay the outstanding shareholder loan from Turquoise Hill Resources to reduce Oyu Tolgoi LLC's cost of debt at the time. Per Oyu Tolgoi LLC's audited financial statements for the year ending 2016, interest on the shareholder loan was accruing at a rate higher than the interest on the Project Finance borrowings with international banking institutions and banks.

Between 13 October 2016 and 11 June 2020, the US\$4.2 billion repayment was advanced to Oyu Tolgoi LLC in the form of shareholder debt or equity in accordance with the Grid Loan 2 agreement. Per the Grid Loan 2 agreement, these funds were specifically for the development of the Hugo North Lift 1 underground mine.

Based on our procedures performed, in accordance with our Supply Order dated 25 November 2021, we verified the receipt of USD 4,274,320,585.41 from Oyu Tolgoi Netherlands BV.



**Building a better
working world**

3

Written Representations from Management

We have requested a letter of representation from Rio Tinto and Oyu Tolgoi management. Copies of these letters are available on request.

Uncorrected misstatements

During the course of our audit, we did not identify any uncorrected misstatements.

This letter has been prepared for the sole use of the Board of Directors, management and others within the Company's. It must not be disclosed to a third party or quoted to or referred to without our written consent. No responsibility is assumed by Ernst & Young to any other person.

Finally, we would like to take this opportunity to thank your staff for the co-operation we have received throughout our audit. If there are any further matters which you wish to discuss concerning our audit, please do not hesitate to call us.

Yours faithfully

Ernst & Young


Ernst & Young



Building a better
working world

4

Appendix 1 - Oyu Tolgoi LLC ownership structure as at the time of funding





Building a better
working world

Ernst & Young
Accountants Limited
11th Floor, 100 Market Street
Sydney, New South Wales 2000
Australia

Ernst & Young
Accountants
11th Floor, 100 Market Street
Sydney, New South Wales 2000
Australia

Independent Auditor's Report to the Directors of Rio Tinto Services Limited and the Joint Venture participants of Oyu Tolgoi LLC

Opinion

We have audited the payments receipted by Oyu Tolgoi LLC from Oyu Tolgoi Netherlands BV amounting to USD4,274,320,585.41 over the period from 13 October 2016 to 11 June 2020 in the form of shareholder debt and equity payments (hereafter referred to as Re-Advance Notice Payments) as presented in the Re-Advance Notice dated 25 May 2020.

In our opinion, in all material respects, the Re-Advance Notice Payments included in the Re-Advance Notice dated 25 May 2020 issued by Oyu Tolgoi LLC have been receipted from Oyu Tolgoi Netherlands BV and receipted by Oyu Tolgoi LLC over the period 13 October 2016 to 11 June 2020.

Basis for Opinion

We conducted our audit in accordance with International Auditing Standards. Our responsibilities under those standards are further described in the *Auditor's Responsibilities for the Audit* section of our report. We are independent of Rio Tinto Services Limited and Oyu Tolgoi LLC in accordance with the ethical requirements of the Accounting Professional and Ethical Standards Board's APES 110 *Code of Ethics for Professional Accountants* (the Code) that are relevant to our audit of the Re-Advance Notice payments in Australia. We have also fulfilled our other ethical responsibilities in accordance with the Code.

We believe that the audit evidence we have obtained is sufficient and appropriate to provide a basis for our opinion.

Emphasis of Matter - Basis of Accounting and Restriction on Distribution and Reliance

The Re-Advance Notice was prepared by Oyu Tolgoi LLC to meet its loan funding requirements per Grid Loan 2 and Grid Loan 3. As a result, the Re-Advance Notice may not be suitable for any other purpose. Our report is intended solely for Rio Tinto Services Limited and the joint venture participants of Oyu Tolgoi LLC (collectively the 'Recipients') and should not be distributed to parties other than the Recipients.

A party other than the Recipient accessing this report does so at their own risk and Ernst & Young expressly disclaims all liability to a party other than the Recipient for any costs, loss, damage, injury or other consequence which may arise directly or indirectly from their use of, or reliance on the report. Our opinion is not modified in respect of this matter.



Building a better
working world

2

Responsibility of the Directors for the Re-Advance Notice

The Directors of Oyu Tolgoi LLC are responsible for preparation of the Re-Advance Notice Payments in accordance with requirements of Grid Loan 2 and Grid Loan 3. This responsibility includes such internal control that the directors determine is necessary to enable the receipt of the Re-Advance Notice Payments are free from material misstatement, whether due to fraud or error.

Auditor's Responsibility for the Audit of the Re-Advance Notice Payments

Our objectives are to obtain reasonable assurance about whether the Re-Advance Notice Payments included in the Re-Advance Notice are free from material misstatement, whether due to fraud or error, and to issue an auditor's report that includes our opinion. Reasonable assurance is a high level of assurance, but is not a guarantee that an audit conducted in accordance with International Auditing Standards will always detect a material misstatement when it exists. Misstatements can arise from fraud or error and are considered material if, individually or in the aggregate, they could reasonably be expected to influence the economic decisions of users taken on the basis of the Re-Advance Notice Payments.

As part of an audit in accordance with International Auditing Standards, we exercise professional judgement and maintain professional scepticism throughout the audit. We also:

- ▶ Identify and assess the risks of material misstatement of the Re-Advance Notice Payments, whether due to fraud or error, design and perform audit procedures responsive to those risks, and obtain audit evidence that is sufficient and appropriate to provide a basis for our opinion. The risk of not detecting a material misstatement resulting from fraud is higher than for one resulting from error, as fraud may involve collusion, forgery, intentional omissions, misrepresentations, or the override of internal control.
- ▶ Obtain an understanding of internal control relevant to the audit in order to design audit procedures that are appropriate in the circumstances, but not for the purpose of expressing an opinion on the effectiveness of the entity's internal control.
- ▶ Evaluate the appropriateness of accounting policies used and the reasonableness of accounting estimates, if any, and related disclosures made by the directors.

We communicate with the Directors regarding, among other matters, the planned scope and timing of the audit and significant audit findings, including any significant deficiencies in internal control that we identify during our audit.

Ernst & Young

Ernst & Young
7 March 2023